



УЛААНБААТАР ЦЭВЭР АГААР ТӨСӨЛ



Улсын нийслэлдээ
Онлаачий амьдарцгаая

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар
Зургийн жагсаалт
Хүснэгтийн жагсаалт
Өмнөх үг
Талархал

БҮЛЭГ 1. ХУРААНГҮЙ

- 1.1 Төвч түүх
- 1.2 Төслийн дэмжиж байгаа эрхэм дээд зорилгууд
- 1.3 Богино хугацаанд авах арга хэмжээ
- 1.4 Дунд шатанд авах арга хэмжээ
- 1.5 Төслийн үр шимийг хүртэгсэд
- 1.6 Төслөөс хүлээгдэж байгаа үр дүнгийн үзүүлэлтүүд
- 1.7 Төслийн санхүүжилт, хэрэгжих хугацаа

БҮЛЭГ 2. ЗУУХНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

- 2.1 Төсөл хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалт
 - 2.1.1 Төслийг удирдах нэгж
 - 2.1.2 Төслийг удирдах хороо
- 2.2 Зорилтот өрхүүд, тэдгээрийн байршил
 - 2.2.1 Эрх бүхий өрхийг сонгох, байршилийг тогтоох
 - 2.2.2 Тандалт судалгаа
 - 2.2.3 Хорооноос ирүүлсэн нэрстэй ажилласан байдал
 - 2.2.4 Дүгнэлт
- 2.3 Зуухны утаа ялгаруулалт үр ашгийг турших лаборатори, зуух хөгжлийн төвийн үйл ажиллагаа
- 2.4 Хөтөлбөрийн менежмент хамтын ажиллагаа
 - 2.4.1 Засгийн газрын тусгай сан-Цэвэр агаарын сан
 - 2.4.2 Хасбанк
 - 2.4.3 ШУТИС-ын дэргэдэх Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн
 - 2.4.4 Төслийн шалгуур үзүүлэлт хангасан нийлүүлэгчид
 - 2.4.5 Хуучин зуух устгалын компани
 - 2.4.6 Хяналтын баг
 - 2.4.7 Дүгнэлт
- 2.5 Борлуулалтын механизм
- 2.6 Гомдол хүлээн авах, шийдвэрлэх механизм
- 2.7 Чанарын хяналтын үйл явц, үр дүн
 - 2.7.1. Танилцуулга
 - 2.7.2. Зорилго
 - 2.7.3. Зорилтууд
 - 2.7.4. Хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаа
 - 2.7.5. Үр дүн
- 2.8 Зуух устгалын компанийд хяналт хийсэн байдал
- 2.9 Төслийн зохицуулалт
 - 2.9.1 Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо
 - 2.9.2 Удирдах дээд байгууллагын дэмжлэг
 - 2.9.3 Мэдээллийн бааз үүсгэх, уялдаа холбоог хангах

- 2.10 Хяналт үнэлгээ-шинжилгээ
 - 2.10.1 Дэлхийн банкны хяналт
 - 2.10.2 Төслийг удирдах хорооны хяналт
 - 2.10.3 Зуухны үйлдвэрлэл-чанарт хийсэн хяналт
 - 2.10.4 ТҮН-ийн дотоод хяналт
 - 2.10.5 Зөвлөх үйлчилгээнүүдэд тавих хяналт

- 2.11 Худалдан авалтын үйл явц, үр дүн
 - 2.12 Татаасын төлбөр, санхүүжилтийн үйл явц
 - 2.12.1 Бүрэн шаталттай сайжруулсан зуухны татаас
 - 2.12.2 Олон нийтэд чиглэсэн компанийт ажлууд, тэдгээрийн санхүүжилт
 - 2.12.3 ТЭЗҮ боловсруулах Зөвлөх үйлчилгээний санхүүжилтийн байдал
 - 2.12.4 Дүгнэлт:

БҮЛЭГ 3. ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА

- 3.1. 2013 оны зорилтууд
- 3.2. Стратеги
- 3.3. Үр дүн

БҮЛЭГ 4. ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО ЧИГ ХАНДЛАГА

- 4.1 Иргэдийн төлберийн чадварт нийцсэн орон сууцны стратеги
- 4.2 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийг боловсронгуй болгох ТЭЗҮ
- 4.3 Улаанбаатар хотын ногоон байгууламж, тарималжуулалтын хөрөнгө оруулалтын ТЭЗҮ боловсруулах
- 4.4 "2,3,4-р цахилгаан станцуудын яндангаас болон үнсэн сангаас ялгарч байгаа тоосонцор, хүхрийн хийг бууруулах ТЭЗҮ

БҮЛЭГ 5. ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 5.1 Төслийн үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт

БҮЛЭГ 6. СУРГАМЖ, ДҮГНЭЛТ

- 6.1. Зорилтын биелэлт, үнэлгээ
 - 6.2. Хүндрэл, сургамж
 - 6.3.Дүгнэлт
- Хавсралт
- Хавсралт №1. Зуухны борлуулалтын мэдээ
- Хавсралт №2. Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт
- Хавсралт №3. ТВ сурталчилгаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн хөгжлийн банк
БДШССБ	Дэлхийн банкны дунд шатны стратегийн санамж бичиг
ДБ	Дэлхийн банк
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДТҮЭХ	Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗУЯУАТ	Зуухны утааны ялгаруулалт үр ашгийг турших лаборатори
ММСС	Монголын Мянганы сорилын сан
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
НАЧА	Нийслэлийн агаарын чанаарын алба
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НӨАТ	Нэмүү өргтийн албан татвар
ОСНААУГ	Орон сууц нийтийн аж ахуйг удирдах гэзар
ОСНААК	Орон сууц нийтийн аж ахуйн компани
ОУСБХБ	Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк
УБЦАТ	Улаанбаатар-Цэвэр агаар төсөл
УБДСТӨХК	Улаанбаатар Дулааны сүлжээ төрийн өмчит хувьцаат компани
ЧХБ	Чанаарын хяналтын баг
ТББ	Төрийн бус байгууллага
ТУН	Төслийг удирдах нэгж
ТУХ	Төслийг удирдах хороо
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЦАС	Засгийн газрын тусгай сан- Цэвэр агаарын сан
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭХЗГ	Эрчим хүчний зохицуулах газар
ЯНХС	Японы нийгмийн хөгжлийн сан
ОУХА	Олон улсын хөгжлийн ассоциаци

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг №1. Төслийг удирдах нэгжийн хамт олон
Зураг №2. Төслийг удирдах хорооны хурал
Зураг №3. "Quantum GIS" програм дээр тэмдэглэгдсэн зуух аваагүй өрхүүд
Зураг №4. Нэрстэй ажиллах зарчим
Зураг №5. Хасбанкны системд орсон зуух авах нийт өрхийг /дүүрэг тус бүрээр/
Зураг №6. УБЦАТ-ийн зуух сонгох үе шат
Зураг №7. Дэлхийн банкны төлөөлөгчид, техникийн зөвлөх компани болон зуухны лабораторийн ажилчдын хамт
Зураг №8. 2013 онд туршилт хийсэн зуухны төрлүүд
Зураг №9. Шалгарсан зуухнууд
Зураг №10. Шалгарсан зуухнуудын харьцуулалт
Зураг №11. Шалгарсан зуухнуудын тоосонцрын харьцуулалт
Зураг №12. Ханан пийшингийн худгууд
Зураг №13. Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах ажиллагаа
Зураг №14. Хас банктай хамтран ажиллах гэрээ байгуулав. 2013.10.04
Зураг №15. Лабораторийг шинэ байршилд дахин угсрав.
Зураг №16. 2013 оны 10-р сарын 11-нд 5 талт хэлэлцээр байгуулав
Зураг №17. Оролцогч талуудтай хийсэн уулзалт
Зураг №18. ММСС-ийн бүтээгдэхүүн борлуулах анхны схем
Зураг №19. УБЦАТ-ийн зуух борлуулах механизм
Зураг №20. ТУН-д ирсэн өргөдөл гомдол
Зураг №21. Чанаарын хяналт хийх үе шат
Зураг №22. Зөвлөх багийн бүтэц, зохион байгуулалт
Зураг №23. Хяналтын багийн гишүүд
Зураг №24. Айл өрхөд хийх хяналтын ажлын бүрдэл
Зураг №25. Хяналт хийсэн өрхийн тоо
Зураг №26. Чанаарын хяналтын үр дүнгийн хураангуй
Зураг №27. Хуучин зуухыг зуух устгалын цэгт буулгаж буй байдал
Зураг №28. Хуучин зуухны эд ангийг эвдсэн байдал
Зураг №29. Хуучин зууханд тэмдэглэгээ хийсэн байдал
Зураг №30. Ачилт хийж байгаа байдал
Зураг №31. Үндэсний хорооны хуралдааны хэсгээс
Зураг №32. УБЦАТ-ийн нээлтийн үеэр.
Зураг №33. Хэсгийн ахлагч нарын нэгдсэн зөвлөгөөны үеэр.
Зураг №34. УБЦАТ-ийн үйл ажиллагаатай танилцав.
Зураг №35. Дэлхийн банкаас төслийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа нь
Зураг №36. Төслийг удирдах хорооны гишүүд хяналт хийж байгаа нь
Зураг №37. Зуухны ўйлдвэрлэлт, чанарт хяналт хийв
Зураг №38. Агуулах-Роял Өүүшн ХХК
Зураг №39. Агуулах-Их Тэнгэрийн Хүч ХХК
Зураг №40. Агуулах-Сэлэнгэ Констракшн ХХК
Зураг №41. Татаасын санхүүжилт хийх ерөнхий схем
Зураг №42. Татаас олгосон зуухны тоо компани тус бүрээр
Зураг №43. Татаасын санхүүжилт (ам.доллараар) компани тус бүрээр
Зураг №44. Зорилтот бүлгүүд ба тэдгээрт чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны гол агуулга
Зураг №45. Мэдээлэл, хамтын ажиллагааны стратеги
Зураг №46. Зөвлөх ўйлчилгээний төлөвлөлт
Зураг №47. Судалгаанд хамрагдсан газрууд, тэдгээрийг үнэлсэн байдал
Зураг №48. Ажлын хэсгийн хурал 2013.12.12-“Тасганы овоо”
Зураг №49. SGS компанийн мэргэжилтнүүд 4-р цахилгаан станц дээр
Зураг №50. 2-р цахилгаан станцийн үнсэн сан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт №1: Судалгаанд хамрагдсан хороод
Хүснэгт №2: Төслийн гол шалгуур үзүүлэлт, зуухны стандарт
Хүснэгт №3: Зуухны туршилтын үр дүнг нэгтгэсэн хүснэгт
Хүснэгт №4: Зуухны татаасны хэмжээ
Хүснэгт №5: Хэрэглэгчтэй холбоотой зөрчлүүд /шалтгаан тус бүрээр/
Хүснэгт №6: УБЦАТ-ийн худалдан авах ажиллагааны арга, босго үнэ,
Дэлхийн банкнаас урьдчилж хийх хяналт
Хүснэгт №7: Нийслэлийн Засаг даргын захирамж
Хүснэгт №8: 2013 онд байгуулагдсан гэрээнүүд
Хүснэгт №9: Зөвлөхөөс боловсруулсан төлөвлөгөө

ӨМНӨХ ҮГ



Нийслэлчүүд бид 2013 онд агаарын бохирдлыг бууруулах томоохон арга хэмжээг хэрэгжүүлж бүрэн шаталттай сайжруулсан зуухыг гэр хорооллын өрхүүдэд хөнгөлтэй үнээр борлуулах, цаашид агаарын чанарыг хамгаалах, сайжруулах чиглэлээр баримтлах бодлогын чиг хандлагаа тогтоох үнэ цэнэтэй алхамуудыг хийлээ. Энэ хугацаанд миний бие Улаанбаатар Цэвэр агаар төслийн Төслийг Удирдах Хорооны даргаар ажиллаж төслийн хэрэгжилт, зохион байгуулалтыг нийслэлийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдуулан зохион байгуулах үргийг гүйцэтгэсэн.

Хүн амын эрүүл мэнд, эдийн засаг, амьдралын чанарт чухал нөлөө бүхий агаарын чанарыг хянах, сайжруулах асуудал нь олон талын оролцоо, хамтын ажиллагааг шаардсан цогц асуудал бөгөөд эдгээрийг нийслэлийн хэмжээнд нэгтгэн зангидах, уялдаа холбоог сайжруулахад бид онцгой анхааран ажилласан.

Энэ чиглэлээр бид Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Байгаль орчин ногоон хөгжлийн яам, Цэвэр агаарын сан, Улаанбаатар- Цэвэр агаар төсөл, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Шинжлэх ухаан технологийн их сургууль, нийлүүлэгчид зэрэг төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, судалгаа шинжилгээ, хэвлэл мэдээллийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг сайжруулж чадлаа.

Зуух солих хөтөлбөрийн явцад гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөх гол хүчин зүйлсийг тогтоож, иргэдийн хэрэглээний хэв маяг, хариуцлагыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэж байна.

Өрхүүдийг бүрэн шаталттай сайжруулсан зуухаар хангахын зэрэгцээ зөв галлах горимыг сурталчлах, дамнан худалдаж ашиг олох үйлдлүүдийг таслан зогсоох зэрэгээр эрх зүйн орчинд зохих өөрчлөлт, шинчлэлт хийх, нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хамtran ажиллаж буй байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулж мэдээллийн нэгдсэн сантай болох, үүрэг хариуцлагын давхардлыг арилгах зэрэг дараагийн зорилтууд биднийг хүлээж байна.

Улаанбаатар Цэвэр агаар төслийн хэрэгжилтэнд гар бие оролцон хувь нэмрээ оруулж, хамtran ажилласан бүх хувь хүмүүс, байгууллагуудад ТУХ-ны нэрийн өмнөөс талархаж буйгаа илэрхийлье. Та бидний хамтын ажиллагаа өргөжин тэлэх болтугай.

Т. Бат-Эрдэнэ

A handwritten signature in black ink, appearing to read "Бат-Эрдэнэ".

УБЦАТ-ийн Төслийг Удирдах Хорооны дарга
НЗД-ын Экологи ногоон хөгжлийн асуудал эрхэлсэн орлогч дарга

ТАЛАРХАЛ



Энэхүү тайлан нь "Улаанбаатар-Цэвэр агаар" төслийн хүрээнд Төслийг удирдах нэгжийн хамт олны 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үйл ажиллагааны цар хүрээг илтгэх баримт бичиг юм.

Монгол Улсын Засгийн Газар нь Дэлхийн банкнаас хөнгөлттэй зээл авч, энэхүү зээлийн хөрөнгөөр "Улаанбаатар-Цэвэр агаар" төслийг (УБЦАТ) хэрэгжүүлэх эрхийг НЗДТГ-т олгосон.

2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр МУЗГ ба ОУХА-ын хооронд байгуулсан "Санхүүгийн гэрээ"-г 2012 оны 5 дугаар

сарын 18-ны өдөр УИХ-аар хэлэлцэн соёрхон баталсан бөгөөд мөн НЗДТГ ба ОУХА-ийн хооронд "Төслийн гэрээ"-г байгуулсан нь уг төслийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн үндэслэл болсон. Энэхүү төслийн зорилт нь гэр хорооллын айл өрхийг утаа бага ялгаруулдаг халаалтын хэрэгсэл /зуух/-ээр хангах замаар агаарын бохирдлыг богино хугацаанд бууруулах болон цаашид хөгжлийн түншүүдтэй хамтран Улаанбаатар хотын дунд хугацаанд хийх ажлын бэлтгэлийг хангахад оршиж байгаа болно. Зорилтод хүрэхийн тулд төслийг (А) Гэр хорооллын нарийн тоосонцор (PM)-ыг бууруулах, (Б) Улаанбаатар хотын төвийн нарийн тоосонцор (PM)-ыг бууруулах, (В) олон нийтийн ухамсарыг дээшлүүлэх стратеги боловсруулах гэж ангилан авч үзсэн бөгөөд ангилал тус бүрт тохирсон нарийн төлөвлөлтийг хийж, хамтрагч талуудыг тодорхойлон гаргасан билээ.

Энэхүү нарийн төвөгтэй бөгөөд хариуцлагатай ажлын бэлтгэлийг хангах, үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулах, төсөлд оролцогч талуудын удирдлагуудад төслийн мөн чанарыг ойлгуулах, Төслийг удирдах нэгжид шаардлагатай заавар, зөвлөмжийг өгөх зэрэгт онцгой үүрэг гүйцэтгэсэн Дэлхийн банкны төслийн багийн ахлагч ноён Гайлиус Ж. Драугелис, зөвлөх Роберт Ван дер Плас болон бусад багийн гишүүдэд талархсанаа илэрхийлье. Түүнчлэн НЗДТГ-ийн нэрийн өмнөөс төслийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, шаардлагатай шийдвэр, зөвлөмжүүдийг цаг алдалгүй гарган бидэнд дэмжлэг туслалцаа үзүүлж ажилласан НЗД-ын экологи ногоон хөгжлийн асуудал эрхэлсэн орлогч ноён Т. Бат-Эрдэнэ болон Төслийг Удирдах Хороонд гүн талархал илэрхийлье.

2013 онд хүлээсэн үүрэг, зорьсон зорилгоо амжилттай биелүүлэхэд бидний хамтрагч талууд болох "Цэвэр агаарын сан", "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо", "Байгаль орчин ногоон хөгжлийн яам", "Эрчим хүчний яам", "ШУТИС-ийн Дулааны техник үйлдвэрийн экологийн хүрээлэн", зуух ханган нийлүүлэгчид, гадаад дотоодын зөвлөх компаниуд, "Хасбанк", нийслэлийн дүүрэг, хороод, хэсгийн ахлагчдын үүрэг их байсан бөгөөд та бүхэндээ хамт олныхоо өмнөөс гүнээ талархал илэрхийлье.

Энэ онд олсон ололт нь дээр дурдсан бүх оролцогч талуудын хүчин чармайлтаар бий болсон ба дараа дараагийн жилүүдэд хийх ажлуудын эхлэл болж байгаа гэдгийг хэлэхэд таатай байна.

Төслийг удирдах нэгжийн захирал

Н. Энхболд

1.1 ТӨВЧ ТҮҮХ

Улаанбаатар хотод өвлийн улиралд агаарын бохирдлын хэмжээ гамшгийн хэмжээнд хүрлээ гэж сүүлийн 10-аад жил ярьж эхэлсэн боловч хөрөнгө төвлөрүүлэн дорвitoй арга хэмжээ авч эхэлсэн нь 2009 оноос билээ.

Амьсгалын замаар дамжин хүний эрүүл мэндэд ноцтойгоор сөрөг нөлөө үзүүлж байгаа нарийн ширхэгтэй тоосонцорын агууламж \PM_{2.5}\-ны гэрийн зуухнаас ялгарч байдгийг судалгаагаар тогтоосон байдал.

МУЗГ олон улсын хандивлагч байгууллагын анхаарлыг агаарын бохирдлыг бууруулах чиглэлд хандуулсны үр дүнд Мянганы сорилын корпораци, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Жайка, Европийн сэргээн босголт хөгжлийн банк, Германы Техникийн хамтын ажиллагаа (GTZ), Хас банк гэх зэрэг олон улсын болон дотоодын байгууллагууд хөрөнгө оруулалт хийх замаар санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэн донорын уулзалтыг хэд хэд удаа зохион байгуулж, стратеги боловсруулсан.

Тухайн үед агаарын бохирдлыг бууруулахад дараах 3 үндсэн бэрхшээл саад учруулж байсан.

1-рт: Санхүүгийн бэрхшээл (МУЗГ-ын эдийн засгийн нөхцөл байдал нь энэ асуудлыг дангаараа шийдвэрлэх боломжгүй байв)

2-рт: Техник технологийн бэрхшээл (Утааны ялгарлын хэмжээг тодорхойлох шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, лаборатори, хэмжилтийн багаж төхөөрөмж дутмаг, техникийн баримт бичиг, стандарт байхгүй байв)

3-рт: Цогц бодлогын дутмаг байдал (Агаарын бохирдлын асуудлыг хариуцсан байгууллага байхгүй, яам болгонд хэлтэс нэгж байвч уялдаа холбоогүй, ойрын болон хэтийн төлөвлөгөө, нэгдсэн бодлого байхгүй байв)

МУЗГ-ын тусгай сан болох "Цэвэр агаарын сан"-г 2011 онд байгуулсан бөгөөд агаарын тухай хуультай болсон. Дээр нэр дурдсан донорууд болон хандивлагчдын үйл ажиллагааны стратеги нь хэн,

юуг, хэзээ, хэрхэн хийх гэдгийг гаргаж ирэхэд чиглэгдсэн юм.

Тухайлбал: Азийн хөгжлийн банк нь Эрчим хүч уул уурхайн яам (хуучин нэрээр)-тай хамтран Зуухны угаа ялгаруулалтын хэмжээ, үр ашгийг турших лаборатори байгуулах, олон улсын мэргэжилтнийг ажиллуулж техникийн туслалцаа үзүүлэхээр шийдвэрлэгчдийн хүчин чадлыг үнэлэх, шинээр загвар гаргаж турших ажлыг хийх, ЖАЙКА НЭДТГ-ЫН Агаарын чанарын албаны ажилнуудыг хэмжилт хийх арга барилд сургах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, Хас банк нь цэвэр хөгжлийн механизмыг Монголд нэвтрүүлэх гэх мэтээр оролцоогоо тодорхойлсон.

Дэлхийн банк 2007 оноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр МУЗГ-тай хамтарч ажиллах ажлыг эхлүүлсэн бөгөөд дараах үндсэн 2 чиглэлээр шат дараатай арга хэмжээ авахаар "УЛААНБААТАР-ЦЭВЭР АГААР" төслийн концепцийг боловсруулсан. Үүнд:

- Богино хугацаанд авах арга хэмжээ
- Дунд хугацаанд авах арга хэмжээ

Эдгээр үе шаттай арга хэмжээнүүдийн хүрээнд хийгдэх ажлын талаарх товч мэдээллийг 1.3 болон 1.4-т товч дурдсан болно.

1.2 ТӨСЛИЙН ДЭМЖИЖ БАЙГАА ЭРХЭМ ДЭЭД ЗОРИЛГУУД

"Улаанбаатар-Цэвэр агаар" төсөл (УБЦАТ) нь Монгол улсын хувьд боловсруулсан Дэлхийн Банкны Дунд шатны стратегийн санамж бичиг (БДШССБ)-тэй \CY 2009-10\ нийцэж байгаа юм. Энэхүү санамж бичигт МУЗГ-ны эдийн засгaa тогтворжуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуу болон эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалах зэрэг заалтуудыг хэрэгжүүлэхэд Дэлхийн Банкны Групп хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ гэж заасан байдаг. Ялангуяа гэр хорооллын иргэдэд чиглэсэн агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр нь энэхүү бодлогод бүрэн нийцэж байгаа болно.

1.3 БОГИНО ХУГАЦААНД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Богино хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд дотроос гэр хорооллын айл өрхийн хэрэглэж байгаа уламжлалт зуухыг "бүрэн шаталттай", утаа ялгаруулалт багатай "цэвэр" зуухаар солих нь нэн тэргүүний асуудал гэж үзсэн.

Мянганы Сорилын Корпораци нь Мянганы сорилын сангаар дамжуулан бүрэн шаталттай зуухны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэн 2010 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба 2012 оны 9 сард энэхүү хөтөлбөр дууссан. Үр дүнд нь 100-аад мянган айл өрх бүрэн шаталттай зуухтай болж агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулсан.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих "Улаанбаатар-цэвэр агаар" төсөл нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаануудын орхигдсон орон зайд нөхөхөөр төлөвлөгдсөн байсан тул "Мянганы сорилын сан" болон "Цэвэр агаарын сан"-гийн 2 үе шаттай хэрэгжүүлсэн зуухны хөтөлбөрт хамрагдаагүй үлдсэн 45000 айл өрхийг хамруулахаар шийдвэрлэсэн. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд "зуухны угаа ялгаруулалт үр ашгийг турших лаборатори" (АХБ-ны санхүүжилтээр тоног төхөөрөмжийт хангаж бий болгосон)-ийн үйл ажиллагааг тогтолжуулах, мэргэжлийн байгууллагад эзэмшиүүлэх нь чухал гэж үзсэн.

Энэ чиглэлээр хийгдсэн ажлын дэлгэрэнгүйг бүлэг 2.3-аас уншина уу.

1.4 ДҮНД ШАТААНД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Зуух солих хөтөлбөрыг хэрэгжүүлэх, түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, "цэвэр" түлшний үйлдвэрлэлийг дэмжих зэрэг богино хугацаанд хэрэгжүүлэх ажлуудыг хийхийн зэрэгцээ дараах олон ажлуудыг хийх нь зүйтэй гэж ярьж бичиж байв Тухайлбал:

- Орон сууцаар гэр хорооллын иргэдийг хангах
- Төвлөрсөн дулаан хангамжийг сайжруулах замаар айлуудын яндангийн тоог цөөлөх
- Цахилгаанаар халаалтыг шийдвэрлэх
- Хийн түлшийг нэвтрүүлэх
- УБ хотыг ногооруулах, цэцэрлэгжүүлэх
- Автомашинд шүүлтүүр тавих, бохирдол ихтэй тээврийн хэрэгслийг хязгаарлах
- Түүхий нүүрсийг дахин боловсруулах гэх мэт

Гэвч эдгээрт хөрөнгө оруулалт хийхэд шаардагдах судалгааны бэлэн материал, ТЭЗҮ, бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн орчин дутагдалтай байв. Иймээс Улаанбаатар цэвэр агаар төслийн санхүүжилтийг

дараах судалгааны болон бодлогын баримт бичгийг боловсруулахад ашиглах нь ач холбогдолтой гэж үзсэн. Үүнд:

- Улаанбаатар хотын ногоон байгууламжийн дутмаг байдлаас үүдэн гарч байгаа дэгдэмхий тоосыг бууруулах (Энэхүү хэсэгт дараах ажлууд багтана. (а) хотын ногоон байгууламжийн өнөөгийн байдалд үнэлгээ өгөх ба хотын хэмжээнд тоос тоосонцрын хэмжээг бууруулах зорилгоор зүлэг, бусад ногоон байгууламжийг тарьж ургуулах хувилбаруудад дүн шинжилгээ хийж, ногоон байгууламжийг сайжруулах зөвлөмж гаргах (б) туршилтын төсөл хэрэгжүүлэх нэг байршилыг сонгон ТЭЗҮ боловсруулах ба ажлын зураг, тендерийн баримт бичгийг бэлтгэх, хянах (в) УБ хотод ногоон байгууламжийн туршилтын төслийн ажлыг гүйцэтгэж, нийслэлтд хүлээлгэн өгөх.)
- Цахилгаан станцуудын яндангийн утаанаас болон үнсэн сангаас ялгарч байгаа тоос тоосонцрыг бууруулах: (Энэхүү хэсэгт дараах ажлууд багтана (а) Улаанбаатарын дулааны цахилгаан станцуудаас ялгарч байгаа утааг хэмжих, сайжруулах төлөвлөгөө гаргах (б) цахилгаан станцуудын үнсэн сангаас гарч байгаа тоосыг бууруулах, үүний байгаль орчинд үзүүлэх нэлэөллийн үнэлгээг хийх, үр дүнтэй шийдвэрлэж болох арга замын талаар зөвлөмж гаргах.)
- Төвлөрсөн дулаан хангамжийг сайжруулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах: (Энэхүү хэсэгт дараах ажлууд багтана: (а) Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн өргөтгөл, засвар шинэчлэлтийн ажлын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах (б) Төвлөрсөн дулаан хангамжийн бодлого, зохицуулалт болон менежментийн чиглэлээр салбарын өмнө тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх: өмчлөл удирдлагын зохицуулалт, төлбөр тооцооны асуудал (дулаан болон халуун усны хэрэглээ тоолуургүй байна, дулааны эрчим хүчний алдагдал) мөн төлөвлөлтийн асуудлыг судлах.)
- Иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны стратеги боловсруулах техник туслалцаа: (Энэхүү хэсэгт дараах ажлууд багтана (а) Улаанбаатар хотод иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууц барихтай холбогдсон бодлого, хууль тогтоомжууд, практик ажиллагаанд үнэлгээ хийх, бодлогоор дэвшиүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд хэр зохицож байгаад дүн шинжилгээ хийх, боломжийн өртөгтэй орон сууцаар хангах хувилбаруудыг санал болгох, олон улсын туршлага, сургамжийг танилцуулах, (б) Бодлого, хөтөлбөрийг тодорхойлох стратегийг боловсруулах.

Эдгээрээс дутахааргүй чухал асуудал нь олон нийтийн ухамсыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгааны компанийг ажил байв.

Гэр хорооллын иргэдэд уламжлалт зуухны яндангаас ялгарч байгаа утааны хорт агууламжийг тайлбарлах, хуучин зуухаа бүрэн шаталттай зуухаар сольсноор эдийн засгийн болоод эрүүл мэндийн талаар ямар үр өгөөж хүртэж болох, зөв галлагaa, аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах нь чухал байв.

Төсөл хэрэгжиж эхэлсэн анхны жил буюу 2013 онд дээрх үндсэн чиглэлүүдээр Төслийг удирдах нэгжийн хамт олны хийж гүйцэтгэсэн ажил, хүрсэн үр дүн, сурсан сургамж, дүгнэлт, анхаарах зүйлс болон цаашид хийх төлөвлөгөөний талаар энэхүү тайланд дэлгэрэнгүй өгүүлэх болно.

1.5 ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЭГСЭД

Энэ төслийн үр шимиийг Улаанбаатар хотын 1.3 орчим сая иргэд, ялангуяа төвийн 6 дүүргийн гэр хорооллын иргэд хүртэх ба эдгээрээс 45000 өрх нь шууд үр шим хүртэгсэд байна.

1.6 ТӨСЛӨӨС ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Зуухны хөтөлбөрт хамрагдаагүй үлдээд байгаа ерхүүдийг утга ялгаруулалтын шаардлагад нийцэн бүрэн шаталттай зуухны хөтөлбөрт хамруулах
- Агаарын бохирдлыг бууруулах дунд хугацааны арга хэмжээний хүрээнд боловсруулсан гол гол зөвлөмжүүд, авах арга хэмжээний төлөвлөгөө болон ТЭЗҮ-г холбогдох талуудаар батлуулах
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа агентлагууд болон хандивлагчдын уялдаа холбоог сайжруулах

1.7 ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

- МУЗГ нь Улаанбаатар Цэвэр агаар төслийг хэрэгжүүлэхээр Дэлхийн Банкнаас 15.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл авсан бөгөөд 25 жилийн хугацаатай, жилийн 1.25%-ийн хүүтэй, 0,75%-ийн шимтгэлтэй.
- Бүрэн шаталттай зуухаар гэр хорооллын иргэдийг хангах, зуухны утааны ялгаруулалт үр ашгийг турших лаборатори болон зуух хөгжлийн төвийг бэхжүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, техникийн туслалцаа үзүүлэх зэрэгт 9.7 сая ам.доллар
- Дунд хугацаанд авах арга хэмжээнд шаардагдах ТЭЗҮ, бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад 2.3 сая ам.доллар
- Олон нийтийн ухамсыг дээшлүүлэх, төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах чиглэлийн үйл ажиллагаанд 3 сая ам.долларыг тус тус зарцуулахаар төлөвлөсөн

Төслийн хөрөнгө зарцуулах эрх нь 2012 оны 12 дугаар сарын 19-нд нээгдсэн бөгөөд 2017 он хүртэл 5 жилийн хугацаанд хэрэгжинэ.

БҮЛЭГ 2

ЗУУХНЫ
ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТ

2.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1.1 ТӨСЛИЙГ УДИРДАХ НЭГЖ

Дэлхийн банкны санхүүжилтэйгээр 2005-2012 онуудад хэрэгжсэн "Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төсөл", "Иргэдийн оролцоог дэмжих төсөл" (ЯНХС), "Улаанбаатар хотын хүрээлэн байгаа орчныг сайжруулах төсөл" (Нидерландын засгийн газрын буцалтгүй тусламж) зэрэг төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн туршлагыг үндэслэн 2011 онд Нийслэлийн Засаг даргын захирамж гарч "Улаанбаатар-Цэвэр агаар" төслийг хэрэгжүүлэх үүргийг Төслийг удирдах нэгжид давхар ноогдуулсан. Төслийг удирдах нэгж нь одоогийн байдлаар 1 зээл 2 буцалтгүй тусламжийн төсөл хэрэгжүүлж байгаа ба нийтдээ 15 хүний бүрэлдхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төслийгудирдах нэгж \ТУН\ -ийн үйл ажиллагааны чиглэл нь дараах байдлаар тодорхойлогдоно. Төслийн бүхий л менежмент, техникийн болон инженерийн асуудлууд, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, санхүүгийн менежмент, хяналт шалгалт, дүн шинжилгээ, тайлан илтгэлийн асуудал хамрагдана.

Төслийг удирдах нэгж нь Төслийг удирдах хороо болон Дэлхийн банкны хяналтын хэсэгт ажлаа тайлагнадаг.



Зураг №1. Төслийг удирдах нэгжийн хамт олон

2.1.2 ТӨСЛИЙГ УДИРДАХ ХОРОО

Нийслэлийн Засаг даргын 2013 оны 1-р сарын 16-ны 31 тоот захирамжаар УБЦАТ-ийн хэрэгжилтэд хяналт тавих, тусламж дэмжлэг үзүүлэх, заавар удирдамжаар хангах зорилго бүхий Төслийн Удирдах Хороо байгуулагдсан. Төслийг удирдах хорооны даргаар Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч ажилладаг бөгөөд бүрэлдэхүүнд нь Эрчим хүчний яам, Цэвэр агаарын сан, Агаарын чанаарын алба, шинжлэх ухааны салбарын болон бусад холбогдох байгууллагын төлөөлөл багтсан байдал.

Тайлант хугацаанд Төслийг Удирдах хороо 3 удаа хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны гарын авлага, байгаль орчин болон аюулгүй ажиллагааны баримт бичгүүдийг хэлэлцэж батлах
- Төслийн 2013 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах
- Зууханд болон үйлдвэрлэгчид тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан 4 зуух үйлдвэрлэгчийг шалгаруулах
- Зууханд төлөх хэрэглэгчийн үнийг хэлэлцэж тогтоох
- Зуухны хөтөлбөрийн түгээлт, борлуулалтын схемийг батлах



Зураг № 2. Төслийг удирдах хорооны хурал

2.2 ЗОРИЛТОТ ӨРХҮҮД, ТЭДГЭЭРИЙН БАЙРШИЛ

Зорилтот өрх буюу төсөлд хамруулж, хөнгөлөлттэй үнээр зуух олгох айл өрхийг тодорхойлохын тулд айл өрхөд тавигдах шалгуур үзүүлэлтийг гаргах шаардлагатай болсон. Энэхүү шалгуур үзүүлэлт нь дараах байдлаар тодорхойлогдсон: Үүнд:

- Өмнө нь татаастай үнээр бүрэн шаталттай "Цэвэр" зуух авч байгаагүй байх
- Гэр хорооллын иргэн байх
- Бүртгэгдсэн хаяган дээрээ амьдардаг байх

Дээрх шалгуур үзүүлэлтийг нэгэн зэрэг хангаж байгаа айлын өрхийг УБЦАТ-ийн зуухны хөтөлбөрт хамрагдах эрх бүхий өрх гэж үзэхээр шийдвэрлэсэн.

2.2.1 ЭРХ БҮХИЙ ӨРХИЙГ СОНГОХ, БАЙРШЛЫГ ТОГТООХ

(i) Бүрэн шаталттай, сайжруулсан зуухны хөтөлбөрт хамрагдах шалгуур үзүүлэлтийг хангасан зуух авч чадаагүй айл өрхүүдийн нэрсийг эцэслэн гаргаж, газрын зурагт байршуулах, (ii) Зууханд хамрагдаагүй үлдсэн айл өрхүүдийн шалтгааныг тодруулах (iii) Зуухны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бэлтгэл арга хэмжээг тодорхойлох

2.2.2 ТАНДАЛТ СУДАЛГАА

Борлуулалтын төвийн тоо болон байршилийг эцэслэх зорилгоор 2013 оны 5-р сарын 13-наас 6-р сарын 7-ны хооронд зуух аваагүй иргэдийн тоог гарган газрын зураг дээр байрлуулахаар тандалт судалгааг явуулсан.


Судалгаанд төвийн 6 дүүргийг хамруулахаар төлөвлөсөн боловч ба ЧД-т зуухны хөтөлбөр 3 жил үргэлжилж нийт айл өрхийн 70-аас дээш хувь нь хамрагдсан байсан ба БЗД-ийн хувьд өмнөх зуухны хөтөлбөртэй холбоотой маргаантай асуудал ихтэй байсан тул энэ 2 дүүргийг түр хойшлуулж, 4 дүүргийг сонгосон.

Ингээд СХД, СБД, БГД, ХУД-ийн гэр хорооллын 50 хорооны хэсгийн ахлагч нартай хамтарч, 89 мянган өрхийн дунд тандалт судалгаа явуулсан. Судалгаагаар 25 мянган өрх зуух аваагүй болохыг гаргасан бөгөөд тэдгээр өрхүүдийг газрын зурагт тэмдэглэсэн.

Хүснэгт №1. Судалгаанд хамрагдсан хороод

Дүүрэг	Хороод
Баянгол	9,10,11,16,20,21,22,23
Сонгинохайрхан	2,3,4,5,6,7,8,9,10,11,18,19,20,22,23,24,25,26,28,30,31
Сүхбаатар	9,11,12,13,14,15,16,17,18,19,20
Хан-Уул	4,5,6,7,8,9,10,12,13,16

Зураг № 3. "Quantum GIS" програм дээр зуух аваагүй өрхүүдийг тэмдэглэв.



Үр дүн:

- Энэхүү судалгаанаас гарсан дунг НАЧА болон ХАС-аас ирүүлсэн дүнтэй (26236 өрх) тулгаж үзэхэд зөрүү маш бага буюу 3% байсан бөгөөд энэ нь бүртгэлд суурилсан баримт бичгийн судалгааны хувьд бодитой дүн байсан юм. Түүнчлэн НАЧА-ны дүүрэг тус бүрт 2 ажилтан томилж ажиллуулдаг бөгөөд хорооны засаг дарга, хэсгийн ахлагчдаас ирсэн нэрсийг нэгтгэх, эцслэх ажлыг эдгээр ажилтнууд хийдэг уламжлал тогтсон байсан.
- Судалгааны дунгээс үзэхэд мэдээлэлд ойр байдаг, харьцангуй боловсролтой, төлбөрийн чадвар сайтай, бичиг баримтын зөрчилгүй өрхүүд илүүтэй төсөлд хамрагдсан байна.

- Мэдээлэл боловсруулалтын шатанд судалгаанд хамрагдсан 150 өрхтэй эргэн холбогдож тодруулга авахад бүрэн шаталттай зуухны ач холбогдлыг сайн ойлгохгүй байх, зөв галлагааны горимыг баримтлахгүй байх зэрэг сүл тал ажиглагдсан. Иймд шалгарсан зуухнуудын давуу талыг сурталчлах, таниулах ажил хийх хэрэгцээтэй болохыг олж мэдсэн.
- Зуух борлуулах төвүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх, алслагдсан айл өрхүүдэд хүрч үйлчлэхийн тулд нүүдлийн буюу өртөөчилсөн хэлбэрийг сонгох нь илүү үр дүнтэй болохыг тогтоосон.

2.2.3 ХОРООНООС ИРҮҮЛСЭН НЭРСТЭЙ АЖИЛЛАСАН БАЙДАЛ

2013 оны 9-р сараас 11-р сарын 1 хооронд Нийслэлийн 6 дүүргээс бүрэн шаталттай зуух авах өрхийн нэрсийг 4 удаа авсан бөгөөд нийт 127 мянган өрхийн нэрс ирсэн.

Эдгээр нэрсийг доорх зарчмын дагуу шалгаж, Хас банкны Эко хэлтэсрүү илгээж байсан.

Зураг №4. Нэрстэй ажиллах зарчим

АЖИЛЛАХ ЗАРЧИМ

НАЧА (Хороод)

Хороодоос ирүүлсэн нэрсийг нэгтгэж, УБЦАТ-руу илгээх

УБЦАТ

Нэрсийг шалгаж, зөрчилтэй хороод руу буцааж, зөрчилгүй хорооддоор баталгаажуулах

Хэрэв зөрчилтэй бол: /РД байхгүй, 1 хүн 2 РД-тэй, .../

НАЧА (Хороод)

7-14 хоног

РД дутууг нөхөж, алдааг арилгаж, УБЦАТ-руу илгээх

УБЦАТ

1-2 хоног

Зуух авсан эсэхийг тулгаж, Хороод руу баталгаажуулахаар илгээх

НАЧА (Хороод)

7-14 хоног

Хорооны ЗД нараар баталгаажуулах

Хас банк

2-3 хоног

Зуух авсан нэрстэй ттуулгаж, системд оруулах

Зөрчилгүй бол 21-23 хоног

Зөрчилтэй бол: 28-35 хоног


Тайлбар:

НАЧА-Нийслэлийн агаарын чанарын албанаас тухайн дүүргийг хариуцсан ажилтан

УБЦАТ-Улаанбаатар-Цэвэр агаарын төслийн шүүлт хийж буй ажилтан

Зураг №5. Хасбанкны системд орсон зуух авах нийт өрхийг дүүрэг тус бүрээр харьцуулж үзвэл СХД-ийн өрхийн нэрс 24 мянга орчим орсон байна.

ДҮҮРЭГ ТУС БУРИЙН ЗУУХ АВАХ ӨРХИЙН НЭРС



ДҮГНЭЛТ

- Зуухны өмнөх хөтөлбөрөөс зуух авч чадаагүй үлдсэн айл өрхүүд нь ихэвчлэн байршилийн хувьд алслагдсан, шинээр нүүж ирсэн, хаягийн зөрчилтэй, орлого багатай, нийгмийн эмзэг хэсэгт хамаарах айл өрхүүд байсан тул мэдээллийг хүргэх, зуухны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өмнөхөөс өөр арга барил шаардаж байсан.
- Агаарын чанарын албаны дүүрэг хариуцсан ажилтнууд нь өмнөх төсөл хөтөлбөрүүд дээр ажиллаж байсан туршлагатай, хороод, хэсгийн ахлагч настай тогтолцоог харилцаатай байсан нь нэrsийг бүртгэж, баталгаажуулах ажилд ихээхэн тус нэмэр болж байсан.
- Харин хороодоос зуух аваагүй иргэдийн нэrsийг УБЦАТ-д ирүүлэхдээ удаа дараа алдаа гаргаж байсан (РД байхгүй, эсвэл үсэг, тоо нь өмнө хойноо орсон, эсвэл өмнө зуух авсан иргэдийн нэrsийг дахин ирүүлсэн) нь нэр шалгах ажиллагааг хүндруулж байв.
- Зуух авах иргэдийн нэrsийн үнэн бодит байдлыг тухайн хорооны засаг даргаар баталгаажуулж байсан нь өмнөх төсөл хөтөлбөрүүдээс илүү хяналттай болгож өгсөн.
- Зуухны хөтөлбөр эхлэхээс өмнө тандалт судалгаа хийснээр өмнөх хөтөлбөрийн давуу сул талыг мэдэж, ажиллах механизм арга барилаа хэлэлцэхэд чухал нөлөө үзүүлсэн.
- Эдгээрийг хураангуйлж хэлбэл 6 дүүргээс 4 удаа зуухны хөтөлбөрт хамрагдах хүснэгтэй нийт 127 гаран мянган иргэдийн нэrs ирсэн ба олон удаагийн шүүлтээр зөрчлийг бууруулсны дараах баталгаажсан нэrs 76 орчим мянга болж Хас банкны системд бүртгэгдсэн.

Хүснэгт №2. Төслийн гол шалгуур үзүүлэлт, зуухны стандарт

Шалгуур үзүүлэлт	Зуухны хүчин чадал	Тоосонцрын хэмжээ	Нүүрс төрөгчийн дутуу исэл	AYK	Үйлдвэрлэх, нийлүүлэх хүчин чадал
Төслийн шалгуур үзүүлэлт	3 кВт-аас дээш	Хамгийн ихдээ 70 mg/Net MJ хүртэл	Хамгийн ихдээ 7 grams/net MJ хүртэл	70%-аас дээш	Сард 6000 (Дотоодын зуух үйлдвэрлэгч 2200-аас дээш)
MNS5216-1:2011 Стандарт	3-7 кВт	285	14	70%-аас дээш	-

2.3 ЗУУХНЫ УТАА ЯЛГАРУУЛАЛТ ҮР АШГИЙГ ТУРШИХ ЛАБОРАТОРИ, ЗУУХ ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсөлд хамрагдах айл өрхийн тоо:

“Улаанбаатар-Цэвэр агаар” төсөл нь Мянганы сорилын сангийн зуухны хөтөлбөр дууссаны дараа хэрэгжиж эхлэхээр гэрээний баримт бичгүүдэд тусгагдсан. НЭДТГ нь ЦАС-тай харилцан ойлголцлын санамж бичиг зурсны дараа өмнөх зуухны хөтөлбөрт хамрагдаагүй гэр хорооллын 45000 айл өрх үлдсэн байна гэж тооцоолсон (үүнд зуслангийн бус ороогүй).

Зуухны шалгуур үзүүлэлт:

Зуухны хөтөлбөрийг эхлүүлэх, шаардлагад нийцсан зуухыг сонгон шалгаруулахын тулд зууханд тавигдах шалгуур үзүүлэлт тодорхой байх шаардлагатай.

ТУН-ийн зүгээс зуух солих хөтөлбөр эхлэхээс өмнө (i) зуухны яндангаар гарч байгаа бохирдлын хэмжээ; (ii) үйлдвэрлэх, нийлүүлэх хүчин чадлын доод хэмжээг зааж өгсөн шалгуур үзүүлэлтийг боловсруулж гаргасан.

Доорх хүснэгтэд төслийн шалгуур үзүүлэлтийг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарттай харьцуулж харуулав.

Зуухыг сонгон шалгаруулах

Зууханд болон хэрэглэгчид тавигдах шалгуур үзүүлэлт (2.2-т дурдсан)-ийг тогтоосны дараа зуухны сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж, зурагт үзүүлсэн үе шатаар хэрэгжүүлсэн.

Зураг №6. УБЦАТ-ийн зуух сонгох үе шат



Зуух туршилтын лаборатори:

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр “Зуухны утаа ялгаруулалт, үр ашгийг турших лаборатори” (ЗУЯУАТ)-ийг 2010 онд байгуулсан. Уг лабораторийг 2013 онд албан ёсоор Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн харьяа “Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн”(ДТҮЭХ)-нд хүлээлгэн өгсөн. Тус лаборатори нь зуухны хүчин чадал, ашигт үйлийн коэффициент болон түлшний шаталтаас үүдэлтэй утааны хийтэй хаягдах нүүрс төрөгчийн дутуу исэл, тоосонцор зэрэг бохирдуулагч бодисуудын агууламжийг хэмжиж тодорхойлдог.

Тус лабораторийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хүчин чадлыг нэмэгдүүлэх, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор “УБЦАТ” хэрэгжих хугацаанд нэмэлт тоног төхөөрөмжөөр хангах, ажилтнуудыг сургах дадлагажуулах, лабораторийг итгэмжлэх, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэх юм.



Зураг №7. Дэлхийн банкны төлөвлөгчид, техникийн зөвлөх комити болон зурагын лабораторийн ажлынхан жамт

Зууны туршилт:

"Улаанбаатар-Цвэр агаар" төслийн хүрээнд нийтийн эзлэхэд бүрэн шалтгаалж, сарайнуулсан зуухыг сонгон шалгаруулж туршилтын ажлын зэрэг олон нийтэд нэвтрүүлж зарлахад гадаад, дотоодын нийт 10 аж ахуйн нэгж, байгууллагаас 15 төрлийн зуухыг туршилтанд хамруулж хүснэгтийг ирүүлжэн. Зуух үйлдвэрлэгчдээс холбогдох материал болон зуухыг 2013 оны 5 сарын 22-ноос 31-ний хооронд "Дулааны техник үйлдвэрийн экологийн хувьзалжн" (ДТҮЭХ)-ийн ЗҮЯЧАТ лабораторийт болон төслийн байранд хүлээн авсан.

Зуух туршилтын ажлыг ижил нехцэлд, нэг төрлийн түүшсөр зуух үйлдвэрлэгчийн албан ёсны төлөвлөгчийг байгуулан хийж нэг залгарын аргачлалаар ТҮН-ийн хийнлэг, Дэлхийн банкны зөвлөх Crispin Pemberton-Pigott-ний удирдлаган дор явуулж үр дүнг боловсруулсан.

Зураг № 8.2013 онд туршилт хийсэн зуухны төрлиүүд

ЗУУХНЫ ТУРШИЛТЫН
ЗУРАГ

Зуух үйлдвэрлэгч	Сэлэнгэ Констракшн ХХК	Сэлэнгэ Констракшн ХХК	Сэлэнгэ Констракшн ХХК
Зуухны загвар	Хас зуух	Өлэй зуух	Гэрийн зуух
Туршилт хийсэн огноо	2013.05.27	2013.05.29	2013.05.30
Туршилтын дугаар	178	180	181

ЗУУХНЫ ТУРШИЛТЫН
ЗУРАГ

Зуух үйлдвэрлэгч		Роил Өүүшн ХХК	Роил Өүүшн ХХК
Зуухны загвар	Уламоклалт зуух	Дэл зуух	Жижиг дэл зуух
Туршилт хийсэн огноо	2013.06.04	2013.06.04	2013.06.05
Туршилтын дугаар	183	184	185

ЗУУХНЫ ТУРШИЛТЫН
ЗУРАГ

Зуух үйлдвэрлэгч	Элиеко ХХК	Их тэнгэрийн хүч ХХК	Сарт-Идэр ХХК
Зуухны загвар	Талс зуух	Bekas-107	Анд зуух
Туршилт хийсэн огноо	2013.06.07	2013.06.11	2013.06.11
Туршилтын дугаар	187	188/190	189

ЗУУХНЫ ТУРШИЛТЫН
ЗУРАГ

Зуух үйлдвэрлэгч	Том хорол ХХК	Роил Өүүшн ХХК	Анард
Зуухны загвар	Том хорол НХПА-01	Дал зуух	АС-7
Туршилт хийсэн огноо	2013.06.10	2013.06.04	2013.06.14/17
Туршилтын дугаар	188	191	192/193

ЗУУХНЫ ТУРШИЛТЫН
ЗУРАГ

Зуух үйлдвэрлэгч	Бурханы Гал ХХК	ЭМ СИ ЖИ БИ ХХК	ЭМ СИ ЖИ БИ ХХК
Зуухны загвар	Дулаан зуух	Hosseven 9006	Hosseven 9004
Туршилт хийсэн огноо	2013.06.18	2013.06.19	2013.06.20
Туршилтын дугаар	182/194	195	196

Зуухны туршилтын үр дүн:

Туршилт хийсэн дээрх 15 төрлийн зуухнаас төслийн шалгуур үзүүлэлт болон зуухны стандартыг дараах 4 төрлийн зуух хангаж, шалгарсан.

Зураг № 9. Шалгарсан зуунууд

ЗУУХНЫ
ТУРШИЛТЫН
ЗУРАГ


Зуух үйлдвэрлэгч	Роял Фүшн ХХК	Сэлэнгэ Констракшн ХХК	Элмеко ХХК	Их тэнгэрийн хүч ХХК
Зуухны загвар	Дал зуух	Өлзий зуух	Талст зуух	Bekas-107
Туршилт хийсэн огноо	2013.06.04	2013.05.29	2013.06.07	2013.06.11
Туршилтын дугаар	184	180	187	188/190

Шалгарсан 4 төрлийн зуухны үр дүнг графикаар харуулбал:

БҮЛЭГ 2

Тоосонцрын хэмжээ /РМ (мГ/МЖ)/

Зураг № 10. Шалгарсан зуухнуудын харьцуулалт



Нүүрс төрөгчийн дутуу исэл /СО(Г/МЖ)/

Зураг № 11. Шалгарсан зуухнуудын тоосонцрын харьцуулалт




#	MNS5216-1:2011 Стандарт	3 кВт-аас дээш	Хамгийн ихдээ 70 mg/Net MJ -аас хүртэл	Хамгийн ихдээ 7 grams/ net MJ -аас хүртэл	Хүснэгт №3. Зуухны туршилтын үр дүнгийн нэгжээн хүснэгт				
					Зуухны хүчин чадал	Тоосонцрын хэмжээ	Нүүрс төрөгчийн дууу исэл	АҮК	70%
1	183 Уламжлалт зуух	-	14	1475	14	14	76%		
2	178 Хас зуух	Сэлэнгэ Констракшин" ХХК	12,0	176	5	5	69%	Тэнцээгүй	
3	180 Өлзий зуух	7	64	5	76%	76%	Тэнцэн		
4	181 Гэрийн зуух	10	188	6	75%	75%	Тэнцээгүй		
5	184 Том дөл	Роял Өүүшн ХХК	11	4	3	3	73%	Тэнцэн	
6	185 Жижиг дөл	5	68	10	10	75%	Тэнцээгүй		
7	187 Талст	Элмеко ХХХ	9	27	6	6	81%	Тэнцэн	
8	188 Том хорол	Том хорол ХХК	13,0	45	13	13	78%	Тэнцээгүй	
9	189 Анд зуух	Серт-Идэр ХХК	7	641	11	11	82%	Тэнцээгүй	
10	190 Bekas-107	Их тэнгэрийн хүч ХХК	7,0	4	7	7	70%	Тэнцэн	
11	191 Номин	Хан Буян ХХК	5,0	3423	15	15	80%	Тэнцээгүй	
12	192 ASE-7	Анаард ХХК	10,7	14235	23	23	76%	Тэнцээгүй	
13	193 ASE-7	9,0		2016	20	20	69%	Тэнцээгүй	
14	194 Дулан	Бурханы гол ХХК	6,0	349	6	6	80%	Тэнцээгүй	
15	195 Hossev-en9006	ЭМ СИ ЖИ БИ ХХК	4,0	463	14	14	60%	Тэнцээгүй	

Төслийн шалгруүр үзүүлэлтийг хангасан
Төслийн шалгруүр үзүүлэлтийг хангагуй

Ханан пийшинд зуухыг аюулгүй угсрах замчламж

Бүрэн шаталттай, сайокруулсан зуухыг ханан пийшинд холбож ашиглах хэрэгцээ, шаардлага их байдаг ч улсын хэмжээнд ханан пийшинтэй холбоотой хүчин төгөлдөр мөрддөгдөж байгаа норм норматив, стандарт, журам байгуулж байсан. Өмнөх жилүүдэд хэрэгжсан зуухны хөтөлбөриүд дээр ханан пийшин будсан, дэлбэрэн гэх тохиолдол хэд хэд бүртгэгдсэн байдаг ба энэ нь “төслийн зуух дэлбэрдэг” гэх буруу сийгүүлэг олон нийтэд өгдөг. ТУН нь “Ханан пийшингийн ашиглалт, аюулгүй ажиллагааны зөвлөмж” боловсруулах бие даасан техникийн зөвлөхийг сонгон шалгаруулсан бөгөөд төслийн шалгуур үзүүлэлтийг хангасан бүрэн шаталттай, сайжруулсан 4 зуухыг хамруулан туршилт, судалгааг хийж гүйцэтгээц. Монголд өргөн хэрэглэгдэг ханан пийшингүүдийн загвараас хэд хэдэн төрлийг сонгон авч, төслийн зуухтай холбон туршилт явуулж, гарсан үр дүнг үндэслэн аюулгүй ажиллагааны зөвлөмжийг боловсруулсан. Нийслэлийн Засаг дарга захирамж гаргаж тус зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон.



Хэвтээ 3 худагтай ханан пийшин


Зөвлөмжийн гол дутгалт:

Бүрэн шаталттай зуухыг зөвхөн дараах төрлийн ханан пийшинд ээжих аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу холбогч зөвшөөрөн.


1. Босоо 3 худагтай ханан пийшин
2. Холимог худагтай ханан пийшин
3. Ханан пийшингийн төгстөлийн худгаас дээш гарсан яндан (Энэ тохиолдолд холболтоос доошх хэсгийг элсээр дүүргэж өгөх)

Хэвтээ худагтай ханан пийшинд аливаа зуухыг холбож ашиглахыг хатуу хориглоно.


Зураг № 12.Ханан пийшингийн худгууд



Босоо 3 худагтай ханан пийшин



Холимог худагтай ханан пийшин



Яндангийн онддөрт тавигдах шаардлага

Зуухны татаасны хэмжээ:

Зуухны яндангаас гарч байгаа бохирдол, зуухны зах зээлийн үнэ, хэрэглэгчийн төлөх боломжтой үнэ, ММСС-ийн төслийн олгож байсан татаасны хэмжээ

зэрэг үзүүлэлтийг үндэслэн шалгарсан 4 төрлийн зуухны татаасны хэмжээг тогтоосон.

Хүснэгт №4: Зуухны татаасны хэмжээ

#	Зуухны загвар	Зах зээлийн үнэ	УБЦАТ-ийн татаасны хэмжээ	ЦАС-ийн татаасны хэмжээ	Хэрэглэгчийн төлөх үнэ
		Төгрөг	Төгрөг	Төгрөг	Төгрөг
1	Өлзий зуух	415 000	192 000	192 000	31 000
2	Дөл зуух	419 360	193 680	193 680	32 000
3	Талст зуух	295 900	132 950	132 950	30 000
4	Векас-107 зуух	275 000	123 000	123 000	29 000

Дүгнэлт:

Зуухны шалгаруулалтыг нээлттэй, ил тод, шударга байх зарчмыг баримтлан явуулсан ба оролцогч бүх талын хяналтан дор гүйцэтгэсэн.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт нь төслийн хүрээнд тавигдаж байгаа шалгуур үзүүлэлтээс сүл байсан ба цаашид сайжруулах шаардлагатай нь харагдаж байв.

Татаасын хэмжээг зуухны зах зээлийн үнээс хэрэглэгчийн төлбөл зохих үнийг хасч гарсан ялгавраар тогтоодог. Хэрэглэгчийн төлөх үнийг тогтоохын тулд оролцогч талуудтай олон удаа, олон талаас нь авч хэлэлцэн боловч үр дүнд нь хэтэрхий багаар энэ үнэ тогтсон нь засгийн газраас болон төслөөс өгөх татаасыг хэмжээг өндөр болгосон сүл талтай. Цаашид үндээр шийдвэр гаргагчид анхаарч ажиллах шаардлагатай нь ажиглагдсан.

- Зуух нийлүүлэгчид (Төслийн шалгуур үзүүлэлтийг хангасан зуух нийлүүлэгчид)
- Зуух устгалын компани
- Чанарын хяналтын баг (Зуухыг хаяган дээрээ зориулалтын дагуу ашиглаж байгааг хянах үүрэг бүхий)

2.4.1 ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН-ЦЭВЭР АГААРЫН САН

2013 оны 3 сарын 12-ны өдөр Засгийн газрын тусгай сан-цэвэр агаарын сан (ЦАС) болон НЭДТГ-ын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг нь “Улаанбаатар-Цэвэр агаар” төслийг хэрэгжүүлэх, хамтран санхүүжилт хийх тухай заасан үндсэн баримт бичиг юм.

Энэхүү баримт бичигт “Улаанбаатар-цэвэр агаар” төслийн хүрээнд 45000 айл өрхөд бүрэн шаталттай зуух борлуулах, зөвхөн лабораторийн туршилтыг давсан, шалгуур үзүүлэлтэд тэнцсэн зууханд татаасыг олгох, төслийн татаасыг УБЦАТ болон ЦАС-аас хамтарч санхүүжүүлэх, татаасын хэмжээ санхүүжүүлэгч тус бүрт 50%-тай байх, зуух борлуулах цэгийн үйл ажиллагааны зардлыг ЦАС-аас хариуцан санхүүжүүлэх гэх мэт заалтуудыг оруулж өгсөн.

2.4 ХӨТӨЛБӨРИЙН МЕНЕЖМЕНТ ХАМТЫН АЖИЛЛАГАА**Зуухны хөтөлбөрт оролцогч талууд:**

- Засгийн газрын тусгай сан-Цэвэр агаарын сан
- Зуух борлуулах цэгүүдийн үйл ажиллагааг хариуцагч Хасбанк
- Зуухны утаа ялгаруулалт, үр ашгийг турших лабораторийг эзэмшигч ШУТИС-ийн дэргэдэх Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн

Зураг № 19 Харицсан сийнээс бичигт гарын усгүүрүүх ажлынгын



2.4.2 ХАСБАНК

Хасбанк нь 2009 оноос зохицан нийслэл хотын агаарын бодиждлын асуудлуудыг хөгжлийнад ирекийн сропцож ирсэн хувийн хөмчлийн компаний юм.

"Улаанбаатар-Цэвэр зэвэр" төслийн дүрмийд Хасбанктай хамтран хөгжлийн болсон дараах Залтгаан байсан:

- 2010-2012 онуудад Мянганы сорилын сангийн хэрэгжүүлсэн "Эрчим хүчиний хэмжилтэй" зуухны жетелберт хамтарч ажилласан туршлагатай
- Гэр хороогийн иргэдийн зуухны жетелберт хамрагдаж байсан эсэх мөрчлийн бааттай, борлуулант түгэлтийг хийнхүү тракер програмытай
- Цэвэр хөгжлийн механизмыг Монголд энэ удаа хэрэгжүүлсэн, хяналтын системийг

ТҮН нь "Улаанбаатар-Цэвэр зэвэр төсөл"-ийн хуреэнд хамтран хөгжлийн хөтөлбөрийг 2013 оны 10-р сарын 4-ний өдөр Хасбанктай байгуулав. Энэхүү хөтөлбөрт Хас банк нь зуурун төвлөсөг шилжүүлэгч "Банк" байжас илүүтэй борлуулант, түгэлтийн механизмын тол борлуулж тал байвал туслахадсан.

Хас банк нь зуурун зөвшөөрөлт хамрагдаж хүснэгээ ирүүлсэн иргэдийн мэдрэгийг Тракер системээс ширж өмнө нь зуух эсэхийг шилгэх, хороон даргаар баталгаажиж, ТҮН-ээр шалгагдсан нарийг системд оруулах, шаардлагатай төхөнчилэгдэх хамгидуулга хийх, нийтийн бүрний зуухны түгэлтийн хувьшигээг гаргах, борлуулалтыг 25 цргээр дамжуулсан хийх, өдөр бүрний 30 орчим түгэлтийн машиныг даган зуухыг байршияд нь бүртжэх авах, татаасын материалыг балтэн ТҮН болон ЦАС-т хургуулж, татаасыг шилжүүлэх гэх зорилтуулжээр хамтран хөгжлийх байна.

Зураг №14. Хас банктай хамтран ажиллах сэргэйлэлтэй байгуулалт. 2013.10.04



2.2.3 ШҮТИС-ИЙН ДЭРГЭДЭХ ДУЛААНЫ ТЕХНИК, ҮЙЛДВЭРИЙН ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

Зуухны утааны ялгаруулалт үр ашгийг турших лаборатори (ЗҮЯЯТ) нь 2010 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр байгуулагдсан бөгөөд Уул уурхай, эрчим хүчиний яам (хуучин нэрэр) -ны харьцанд түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулж байсан ба 2012 оны 4-р сараас эхэн АХБ-ны санхүүжилт дууссантай холбоотойгоор түрээстэх асуудал бас дуусгавар болсон юм. Иймээс "Уланбаатар-Цэвэр агаар" төслийн хуреэнд ЗҮЯЯТ-ийн үйл ажиллагааг дахин сэргэж хэвийн ажиллуулах, цаашдын тогтвортой байдлыг хангах нь нэн тэргүүний асуудал байсан. Учир нь энхуу лаборатори нь зуухны хорт угаа ялгаруулалтыг шалгах шинэхэн ухааны үндэслэлтэй чужал платформ болохкоос гадна зуухыг сонгон шалгаруулах, зуух-түлшний ажиллагааг турших, бодит үр дүнг тооцороход нэн шаардлагатай бааз болж байв.


Лабораторийг дахин угсарч, хэвийн ажиллагаанд оруулахад хяналт тавьж, зөвлөгөө өгөх, дотоодын зөвлөх багийн боловсруулсан тайлан зөвлөхийг хянах баталгаажуулах, сургалт явуулж, чадваажуулах ажлыг гүйцэтгүүлжээр гадаад мэргжилтэн (Кристин Пемберстон)-г урж ажиллуулсан. ШҮТИС-ийн

дэргэдэх Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн (ДТҮЭХ)-тэй хамтран ажиллах хэлэлцэрийг 2012 оны 12-р сарын 26-нд байгуулсан. ДТҮЭХ-ийн ажилтнууд нь гадаадын зөвлөх мэргжилтэн болон дотоодын Зөвлөх багийн туслаамжтайгаар түршилтиг бие дааж хийх боломжтой болсон ба цаашид Зуух хөгжлийн төвтэй үйл ажиллагаагаа ялдуулах замаар лабораторийг улам боловсронгуй болгохоор ТҮН-тэй хамтран ажиллаж байна.

Хамтран ажиллах гэрээгээр ДТҮЭХ нь зуухны утааны хорт агууламжид түршилт хийх, лабораторийг хэвийн ажиллуулалжаас гадна дотоодын зуух үйлдвэргэгчдийн зуухыг ут түршилтад оруулах боломжоор хангах юм. Мен түүчинэн ДТҮЭХ нь өөрийн харьяанд байдаг темрийн цехийг "Зуух хөгжлийн төв" болгон өөрчлөн шинчилэх ба ут төөвөр дотоодын зуух үйлдвэргэгчдэд үйлдвэрлэсн зуухныхаа зураглагвар, техникийн асуудлуудыг сайхнуулахад тусалж, үнэ талбергүйгээр зөвлөгөө өгч ажиллах юм. ДТҮЭХ нь хамтран ажиллах гарзаний хуреэнд "Цэвэр агаар төсөл"-өөс тодорхой хэмжээний санхүүгийн демократийг авч үйл ажиллагааны эмдэлд зарцуулах юм.



Зураг №15. Лабораторийг шинэ байршилд дахин утрав.



2.4.4 ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТХАНГАСАН НИЙЛҮҮЛЭГЧИД

Энэхүү тайлангийн 2.2-т дурдсанчлан "Зуухны угааны ялгаруулалт үр ашгийг турших лаборатори" (ЗУЯYAT)-ийн туршилтаар 4 зуух тэнцэн.

Зууханд болон үйлдвэрлэгчид тавигдах шалгуур үзүүлэлтийг нэгэн зэрэг хангасан зуух ханган нийлүүлэгч компаниудаас 2 нь Мянганы сорилын сангийн зуухны хөтөлбөрт шалгаран оролцож байсан юм. Эдгэр нь:

- Сэлэнгэ констракшн ХХК (Өлзий зуух)
- Роял Өүүшн ХХК (Дөл зуух)

Харин Их тэнгэрийн хүч ХХК (Бекас-107 зуух), Элмеко ХХК (Талст зуух) компаниуд нь УБЦАТ-ийн хүрээнд шалгаран гарч ирсэн ю.

Эдгэр компаниутдай төсвэлд хамтран оролцож хэвлэвэрийг байгуулахын емне дараах асуудлуудыг наг бүрчлэн хэлэлцэн тохиролцох шаардлагатай болсон

- Зуух тус бурийн үнэ (Үйлдвэрлэл, тээвэр, түгээлт, сууринтуулалт орсон үнэ)
- НӨАТ-ийн асуудал
- Галийн асуудал
- Нэгж зууханд хэрэглэгчдийн талех үнэ
- Татаасын хэмжээ (Үүнээс УБЦАТ-ийн талех хэмжээ)
- Чанарын асуудал
- Гологдол барагдуулах асуудал
- Борлуулалтын дараах үйлчилгээ гэх мэт

Дээрх асуудлуудыг нууцтай олон талаас нь хэлэлцэн Дэлхийн банк болон ТҮХ-нд танилцуулсны дараа 2013 оны 10-р сарын 4-еес 11-ний хооронд ТҮН нийлүүлэгч тус бүртэй хэвлэлээр байгуулсан Түүнчлэн оролцогч бүх талуудтай хамтран оролцож 5 талт хэлэлцээрийг (НЭДТТ, УБЦАТ, ЦАС, ХАСбанк, Нийлүүлэгчид) 2013 оны 10-р сарын 11-ний өдөр байгуулсан.

Зураг №16. 2013 оны 10-р сарын 11-нд 5 талт хэлэлцээр байгуулав



2.4.5 ХУУЧИН ЗУУХ УСТГАЛЫН КОМПАНИ

2013 оны 10 сарын 7-ны өдөр “Эгэл тансаг” ХХК-тай хуучин зуух устгах чиглэлээр хамтран ажиллах хэлэлцээр байгуулав.

Энэхүү хэлэлцээрийн зорилго нь айл өрхүүдээс хураагдсан хуучин зуухыг дахин зуухны зориулалтаар ашиглах боломжгүй болтол нь эвдсэний дараа төмөрлөгийн үйлдвэрт түүхий эд болгон тушаахад оршино. Энэхүү үйлчилгээг үзүүлсний төлөө тус компани нь ямарч төлбөр авахгүй бөгөөд хаягдал төмрийг борлуулсан орлогоосоо зарлагага нөхөх байдлаар санхүүжихээр хэлэлцээрт тусгагдсан.

Зуух устгалын компанийд тавигдах шаардлага нь хамгийн багадаа 1 га-талбайтай газар эзэмшдэг буюу түрээслэдэг байх, харуул хамгаалалттай байх, зуухыг устгах тоног төхөөрөмжтэй, хүн хүчний нөөцтэй байх.

2.4.6 ХЯНАЛТЫН БАГ


Зуухны чанар, сууринуулалтад хяналт тавих үүрэг бүхий компани, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулан “Ирээдүйн гарц” ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү хяналтын багт тавигдах гол шаардлага нь гэр хорооллын орчин нөхцөлийг сайн мэддэг баг хамт олонтой, гэр хорооллын иргэдийн дунд үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай байхад оршиж байв. Гэр хорооллын иргэд нь хөнгөлөлттэй

үнээр авсан зуухаа бусдад бэлэглэх, дамжуулах, ашиг олох зорилгоор худалдах явдал түгээмэл байгаа бөгөөд энэ нь төсөл хөтөлбөрөөс хүлээгдэж байгаа үр дунд сөргөөр нөлөөлж байгаа юм. Өмнөх төсөл хөтөлбөрүүдээс ялгаатай хяналтын баг тусгайлан ажиллуулж байгаагаараа УБЦАТ онцлог бөгөөд хянах үйл ажиллагааг хариуцлагын механизмыг хууль эрх зүйн орчиноор дэмжиж ажиллах нь ихээхэн чухал байгаа нь төсөл хэрэгжүүлсэн 4 сарын үйл явцаас тодорхой байна.

2.4.7 ДҮГНЭЛТ

- Төслийн хамтрагч талуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагаанаас төслийн үр дүн хамаарч байсан учраас 2 долоо хоног тутамд 1 удаа уулзалтуудыг зохион байгуулж байсан нь их ач холбогдолтой болсон.
- Энэ хугацаанд ПР-ийн болон лабораторийн зөвлөх баг, нийлүүлэгчид, Хасбанк, НАЧА, ЦАС болон дүүрэг хороодтой нийтдээ 49 хамтарсан хурлыг зохион байгуулжээ.
- 800 хэсгийн ахлагчтай хийх уулзалтыг зохион байгуулж, засаг захиргааны нэгж байгууллагын анхаарлыг зуухны хөтөлбөр рүү хандуулсан.

Зураг №17. Оролцогч талуудтай хийсэн уулзалт




2.5 БОРЛУУЛАЛТЫН МЕХАНИЗМ

Борлуулалтын механизмын гэдэг нь нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хэрэгжиж байгаа бүрэн шаталттай, сайжруулсан зуухыг гэр хорооллын иргэдэд хүргэх төслийг хэрхэн төвөг чирэгдэл багатай, өндөр зохион байгуулалттайгаар түгээх, борлуулах тухай аргачлалыг хэлнэ. Зуух борлуулах механизмын оролцогч бүх талын үүрэг, хариуцлага өндөр байснаар нь гарах үр дүн сайн байна.


Монголын Мянганы сорилтын сангийн (ММСС) "Цэвэр агаар" төслийн хурээнд хэрэгжсэн гэр хорооллын айл өрхүүдэд бүрэн шаталттай, сайжруулсан зуухыг борлуулах механизм нь анх дараах схемтэй байсан.

Зураг №18. MMSC-ийн бүтээгдэхүүн борлуулах анхны схем



Энэхүү анхны схем дээр үндэслэн "Улаанбаатар-Цэвэр агаар" төслийн (УБЦАТ)-ийн түгээлт борлуулалтын аргачлалыг боловсруулсан.

Зураг № 19. УБЦАТ-ийн зуух борлуулах механизм



Зуух борлуулах механизмын тайлбар:

- Хорооны байранд байрлах зуух борлуулах төв дээр хэрэглэгч очиж тэнд тавигдсан 4 төрлийн бүрэн шаталттай зуухны загвартай танилцаж, өөрт тохирих зуухыг сонгон гэрээ байгуулж, нэхэмжлэх авах.
- Банкны салбарт очиж нэхэмжлэхийн дагуу хэрэглэгчийн төлөх зуухын үнийн дүнг тушаах.
- Төлбөр төлсөн мэдээллийг банкны системээс зуух нийлүүлэгчдэд мэдэгдэх.
- Зуух нийлүүлэгч төлбөр төлсөн мэдээллийг үндэслэн тухайн хэрэглэгчтэй холбогдох зуухыг хүргэж, суурилуулж өгөх боломжтой өдөр, цагийг товлож, зуух суурилуулах бэлтгэлийг хангуулах.
- Нийлүүлэгч суурилуулалт хийх айлын жагсаалтыг гаргаж банктай хамтран түгээлтийн хуваарь гаргах.
- Нийлүүлэгч нь хэрэглэгчтэй товлон хугацаандaa банкны төлөөлөгчийн хамт зуухыг хүргэж, суурилуулж, ашиглалааны зааварчлагааг өгч, хуучин зуухыг хураан авах. Банкны төлөөлөгч тухайн хэрэглэгчийн байрлалыг тодорхойлж банкны системд бүртгэж авна.
- Нийлүүлэгч хураан авсан хуучин зуухаа Хасбанкаас дүүрэг тус бүрт байрлуулсан агуулахад хүлээлгэн өгөх.
- Зуух суурилуулсан тухай мэдээллийг үндэслэн Банк хэрэглэгч тус бүрийн татаасын материалыг бэлтгэж ТҮН-д 7 хоног бүр хүргэж өгөх.
- Хасбанкаас ирүүлсэн татаасны материалаас иргэдийн мэдээллийг авч Чанарын хяналтыг баг тухайн айлд 7 хоногийн дараа очиж зуухаа бүртгэгдсэн хаяган дээрээ ашиглаж байгаа эсэхийг шалгах.

10. Чанарын хяналтын баг нь шалгалтаар зөрчилгүй болох нь тогтоогдсон айлуудын жагсаалтыг гарган ТУН-д хүлээлгэн өгөх.
11. Банкны болон Чанарын хяналтыг багийн ирүүлсэн материалыг үндэслэн УБЦАТ-өөс санхүүжүүлбэл зохих татаасыг нийлүүлэгч компанид шилжүүлэх.
12. Татаасыг нь шилжүүлсэн хэрэглэгчийн жагсаалтыг ТУН баталгаажуулан Засгийн газрын тусгай сан-Цэвэр агаарын санд (ЦАС)-д хүргүүлэх.
13. УБЦАТ-ийн ТУН-ээс баталгаажуулан ирүүлсэн хэрэглэгчийн нэрс болон төлбөрийн баримт бичгийг үндэслэн ЦАС-аас Зуух нийлүүлэгчдэд татаасыг шилжүүлэх.
14. Хуучин зуух устгалын компани ТУН-д устгал хийгдсэн зуухны тайланг сар бүр тайлagna.
15. ТУН-ийн зүгээс Хуучин зуух устгах компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тодорхой хугацаанд газар дээр очиж шалгалт хийх.
16. ТУХ, АББҮХороо болон бусад холбогдох байгууллагуудад төслийн явцын талаар тайлан хүргүүлэх. Тулгарч байгаа асуудал байвал тавьж шийдвэрлүүлэх.
17. Нийслэлийн экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн зүгээс дүүргийн дарга нарт төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар үүрэг даалгавар өгөх.
18. Дүүргийн зүгээс тухайн хороодын Засаг дарга нартаа төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар үүрэг даалгавар өгөх.

Сургамжаас суралцсан нь:

УБЦАТийн хүрээнд боловсруулсан түгээлт-борлуулалтын механизм нь МСС-ийн зуухны хөтөлбөрт хэрэглэж байсан механизмын үед ажиглагдсан сүл талуудаас суралцах, сайжруулах зорилго тавьснаараа онцлог байв. Эдгээр сүл талуудыг дурдвал:

- Эмнөх зуухны хөтөлбөрийн үед “Хасбанк”-аас ирүүлсэн татаасын материалыг ЦАС хүлээн авсны дараа баталгаажуулахаар НАЧА-руу илгээдэг байв НАЧА цааш нь дүүрэг рүү, дүүрэг хороо рүү, хороо нь хэсгийн ахлагч нар руу явуулж баталгаажуулалт хийгдсний дараа яг энэ шат дамжлагаар буцаж ЦАС-нд ирдэг, энэ бүх процесийн дараа санхүүжилт хийгддэг байсан нь нийлүүлэгчийг санхүүгийн хүнд байдалд оруулдаг байв.
- Хасбанк нь бүртгэл, зуухны маркетинг, борлуулалт, түгээлтийн хяналт, хуучин зуух хураан авах, чанарын хяналт мониторинг зэрэг бүхий л үйл ажиллагаанд голлон оролцдог байсан нь нэгж борлуулах төвд ноогдох зардлыг ихэсгэж, бусад оролцогч талуудын жигд

оролцоог хязгаарлах, харилцан хяналттай байх зарчим алдагдах зэрэг сүл талуудтай байв.

- Нийслэлийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа боловч энэхүү төсөл хөтөлбөрт НЭДТГ-ын оролцоо хязгаарлагдмал байсан ба бүртгэл замбараагүй, хариуцах эзэнгүй байснаас үүнийг тойрсон хэл ам тасардаггүй байв.

ДҮГНЭЛТ:

НЭДТГ нь УБЦАТ-ийг ТУН-ээр дамжуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд ялангуяа зуух солих хөтөлбөрт нийслэлийн харьяа байгууллагууд, засаг захиргааны нэгжүүд, хэсэг, хороо, дүүргийн оролцоог хангаж, уялдаа холбоог сайжруулахад анхаарч, бодлогоор чиглүүлж байдгаараа онцлог юм. Төсөл хэрэгжих явцад дараах давуу талууд ажиглагдсан.

- Хороо, хэсгийн дарга нарын гарын үсэгтэйгээр баталгаажин ирсэн зуух авах эрх бүхий (шалгуур үзүүлэлтийг хангасан) иргэдийн мэдээлэл нь НАЧА-ны дүүрэг хариуцсан ажилтан дээр шалгагдсаны дараа ТУН-ийн болон Хасбанкны бүртгэлийн системээр давхар шалгагддаг.
- Олон нийтэд чиглэсэн зуухуулга сурталчилгаа (PR)-г мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэхийн зэрэгцээ борлуулалтын 25 цэг дээр зуухны маркетингийг хийсэн.
- Суурилагдсан зуухнуудын газар зүйн мэдээллийг Хасбанкны бүртгэлийн системд оруулсны дараа Чанарын хяналтын багийг тухайн айл өрхөд 2 удаа очиж шалгалт хийлгэж байгаа нь өмнөх төсөл хөтөлбөрт байгаагүй шинэ арга барил байв.
- Борлуулалтын цэгүүдийг шинээр гэр хороололд байгуулах биш хорооны байранд байршуулж ажиллуулснаар халаалт, харуул хамгаалалт, гэрэлтүүлэг, түлш, хогонд зарцуулах зардлыг хэмнэхээс гадна иргэний хороотойгоо байнга харилцаатай байдаг боломжийг зуухны хөтөлбөрт ашиглах боломж байгааг олж харсан
- Эдгээрийг төслийн менежментэд оруулж ирснээр оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тэнцвэржүүлж, уялдаа холбоог сайжруулсан гэж дүгнэж байна.

2.6 ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

“Улаанбаатар-Цэвэр агаар” төслийн зуух солих хөтөлбөрийн түгээлт, борлуулалт, сууринуулалт эхэлснээс хойш буюу 2013 оны 10 дугаар сарын 10-наас иргэдээс гомдол хүлээн авах, шийдвэрлэх механизмыг нэвтрүүллээ.

Энэхүү механизмын зорилго бол хариуцлагатай байдлаа дээшлүүлэхэд нь ТҮН-д дэмжлэг үзүүлэх явдал бөгөөд энэхүү зорилгыг дараах хоёр үүргийг биелүүлэх замаар хангана. Үүнд: (а) төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд учирч буй асуудлын талаарх (саад бэрхшээл) мэдээллийг бий болгож түүнийг шийдвэрлэн харилцагч/иргэд болон ТҮН-ийн хоорондын сайн харилцааг бататгах (б) ТҮН-д хөтөлбөрийн үйл ажиллагааг зохих хууль эрхзүй, журмын дагуу гүйцэтгэж буй эсхэд хяналт тавих боломжийг олгох.

Иргэдээс ирж буй гомдол, санал, хүсэлтийг бичгийн болон утсан, мөн цахим хэлбэрээр тус тус хүлээн авч бүртгэх зорилт тавьсан. Утсаар ирсэн санал, гомдол, хүсэлтийг тэмдэглэх бүртгэлийн хуудсыг гаргаж ажилтан бүрт тараасан бөгөөд энэхүү хуудас нь гомдол гаргасан иргэний нэр, регистрийн дугаар, эргэн холбоо барих утас, гомдол, хүсэлтийн утгыг илтгэхээс гадна хэдийд гомдол саналыг хүлээн авсан, хэрхэн шийдвэрлэсэн тухайг товч тэмдэглэж, гарын үсгээр баталгаажуулахад чиглэгдсэн. Утсаар ирсэн гомдол, санал, хүсэлтийг хариуцсан ажилтан нэгтгэж сар бүрийн эцсээр тайлагнадаг. Утсан хэлбэрээр ирсэн гомдол, хүсэлт саналын тухай бүрд нь буюу хурдан хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй. Тайлант хугацаанд нийтдээ 226 иргэн утсаар хандсан бөгөөд тэдний тодруулга, асуултын дийлэнх нь хөнгөлөлттэй

үнээр зуух авахаархүсэлт гаргасан иргэдийн нэrsийн жагсаалтанд өөрийн нэр байгаа эсэхийг шалгуулах зорилготой байв.

Бичгээр ирсэн санал, гомдол, хүсэлтийг хүлээн авсны дараагаар ТҮН-ийн хамт олны хуралд танилцуулан хэлэлцүүлж гарсан шийдвэрийг иргэнд холбогдох утсаар нь эргэж мэдээлдэг бөгөөд энэ хугацаа хамгийн ихдээ ажлын 28 хоног байв.


Тайлант хугацаанд буюу 2013 оны 11 дүгээр сарын 14-нөөс 12 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд тус нэгжид нийтдээ 31 өргөдөл хүсэлт бичгээр ирснээс хамт олны хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн нь 16 байна. Шийдвэрлэх шатандaa 15 байна. Өргөдөл хүсэлтүүд албан ёсны бүртгэлтэй хаяг дээрээ байхгүй тул өөр хаяг дээрээ зуухаа сууринуулах, оронд нь хураалгах хуучин зуухгүй байх, хэн нэгний нэрийн өмнөөс авах гэсэн үндсэн агуулгатай байв.

Тайлант хугацаанд өмнөх төсөл хөтөлбөрүүдээс зуух авсан боловч галд шатсан тул дахин авах хүсэлтээ илэрхийлсэн нийт 15 иргэний өргөдлийг баталгаажуулсан баримтын хамт хүлээн авч бүгдэд нь дахин олгуулахаар шийдвэрлэсэн.

ТҮН-ийн гомдол хүлээн авч шийдвэрлэх механизмын зэрэгцээгээр НЗДТГ-ын дэргэдэх “Улаанбаатар сонсож байна” өргөдөл, гомдол, санал хүсэлтийн цахим системээр дамжуулан төсөл, хөтөлбөрийн мэдээлэл, лавлагааг хүргэлээ. 2013 оны 10 дугаар сарын 17-ноос 12 дугаар сарыг дуусах хүртэлх хугацаанд нийт 2003 иргэний хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн мэдээлэл хүргэж ажилласан.

Зураг №20. Цахим системийн өргөдлийг оруулаагүй болно.

НИЙТ ӨРГӨДӨЛ-46



2.7 ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ҮЙЛ ЯВЦ, ҮР ДҮН

2.7.1 ТАНИЛЦУУЛГА

УБЦАТ-ийн хүрээнд хөнгөлөлтэй үнээр зуух худалдан авсан айл өрхөд, чанарын хяналт хийх зөвлөхийн үйлчилгээг Дэлхийн Банкны худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулсан ба тус ажлыг "Ирээдүйн Гарц холбоо" ТББ гүйцэтгэж байна. Гэрээг 2013 оны 11 дүгээр сарын 13-нд байгуулсан. Үргэлжлэх хугацаа 1 жил.

2.7.2 ЗОРИЛГО

(I) Нийлүүлэгчийн ханганд нийлүүлж байгаа зуух нь чанарын шаардлага болон төслийн

шалгур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг хянан баталгаажуулах, (II) зуух худалдан авсан айл өрхүүд нь зуухаа бүртгэгдсэн хаяг дээрээ ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих (III) Чанарын баталгаажуулалтын системийг боловсруулж хэрэгжүүлэх

2.7.3 ЗОРИЛТУУД

Зорилт 1. Чанарын баталгаажуулалтын ажлын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх

Зорилт 2. Зуух худалдан авсан айл өрхөд хяналт хийх

Зорилт 3. Хуучин зуух хураах, устгах цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих

Зураг №21. Чанарын хяналт хийх үе шат



2.7.4 ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 1-ийн хүрээнд: Чанарын баталгаажуулалтын ажлын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх

Чанарын баталгаажуулалтын ажлын төлөвлөгөөг гэрээ байгуулсан өдрөөс хойш б долоо хоногт багтаан зөвлөх баг боловсруулж төлөвлөгөөний эхний хувилбарыг ТҮН-д хүлээлгэн өгсөн. Чанарын хяналтыг хэрхэн хийх арга зүй, аргачлалаа сайжруулах, ажлын удирдамжийн дагуу бүх ажлыг орхигдуулалгүй төлөвлөхийг сануулж ТҮН албан бичгээр зөвлөгөө өгсөн.

Зураг №22. Зөвлөх багийн бүтэц, зохион байгуулалт

Зорилт 2-ын хүрээнд: Зуух худалдан авсан айл өрхөд эхний хяналтыг хийх

Төслийн хүрээнд зуух худалдан авсан айл өрх бүрт 2 удаагийн хяналтын ажлыг зохион байгуулах нь зөвлөх багийн гол үүрэг юм. Зөвлөх баг нь Уб хотын төвийн 6 дүүргийн 92 хороонд 60 хяначтайгаар хяналтын ажлыг гүйцэтгэж байна.




Хяналт хийх явцад (I) хэт алсладмал гэр хорооллоор явах, (II) хаяжилт муугаас айлаа олохгүй байх, (III) нүүсэн, шилжсэн, өдрийн цагаар эзэнгүй айл өрхүүд олон таарах, (IV) нохойд хазуулах, согтуу хүнтэй харилцах зэргээс үүдэн хяналтын ажилтнууд ажлын байрандаа тогтвортой суурьшилтай ажиллахгүй

байх эрсдэл гарсаар байсан. Эдгээрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ЧХБ нь шинэ ажилтнуудыг бэлтгэх 2 төрлийн сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Үүнд:

- Хяналтын ажлын арга зүй
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа

БҮЛЭГ 2


Зураг №23. Хяналтын багийн гишүүд



Нэг хянаачг ёдөрт хамгийн багадаа 10 өрхеэр орох ба айл өрх бүрээс зуух суурилагдсан эсэх, галын аюулгүй байдлыг хангасан эсэх, зөв галигаааны

заавар зөвлөгөө авсан эсэх талаар асуумж авч, зуухны болон серийн дугаарын зургийг дарж баталгаажуулах үүрэг хүлээндэг.

Зураг №24. Айл өрхад хийх хяналтын ажлын бүрдэл



Зураг №25. Хяналт хийсэн өрхийн тоо



ЧХБ-тай гэрээ байгуулсан өдрөөс тайлан бичих хугацаа хүртэл 6 долоо хоног өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд Хас Банкнаас зуух нь суурилагдсан 11,425 иргэний нэrsийн жагсаалт ирснийг ЧХБ-т хүргүүлсэн. Үүnээs 6,343 айл өрхөд зуухны хяналтыг хийгээд байна.

Зорилт 3-ийн хүрээнд: Хуучин зуух хураах, устгах цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих

Зөвлөх баг нь тайлант хугацаанд хуучин зуух хураах үйл ажиллагаа болон устгах үйл ажиллагаанд хяналт хийж эхлээгүй байлаа. Харин ТУН-нь энэхүү хяналтыг хийж гүйцэтгэж байгаа болно. Дэлгэрэнгүйг бүлэг 2.8-аас харна уу.

2.7.5. ҮР ДҮН

Зураг №26. Чанарын хяналтын үр дүнгийн хураангуй



Үр дүн 1. ЧХБ-ийн илрүүлсэн зуухыг нь суурилуулж өгөөгүй, шошго хадаагүй гэх нийлүүлэгчтэй холбоотой 235 зөрчлийг компани тус бүрээр нь ангилж, залруулах үргийг ТҮН-аас өгсөн. Өгөгдсөн үргийн дагуу Их тэнгэрийн хүч ХХК 5, Сэлэнгэ консракшн ХХК 23, Роял Өүүшн ХХК 8 айл өрхийн зуухыг нөхөн суурилуулалт хийсэн.

Үр дүн 2. Чанарын хяналтын үр дүнд хэрэглэгчдээс шалтгаалах 423 асуудалтай айл өрхүүд байгааг олж тогтоосон ба тэдний хаяг байршил,

Хүснэгт 5. Хэрэглэгчтэй холбоотой зөрчлүүд /шалтгаан тус бүрээр/

Шалтгаан	Өрхийн тоо
Хаяг дээрээ байхгүй /нүүсэн/	244
Эзгүй байсан	124
Зуухаа бусадтай сольсон, зарсан	47
Гэртээ оруулаагүй	4
Амбаар, грашд суурилуулсан	4

Үр дүн 3. Хас Банкнаас ирүүлж байгаа зуух авахаар гэрээ байгуулсан иргэдийн нэrsийн жагсаалтад тулгалт хийж, серийн дугааргүй болон серийн дугаар давхардсан, регистрийн дугаар давхарсан айл өрхүүдийн нэrsийг гарган Хас Банк болон нийлүүлэгч компаниудад илгээж дутагдуудыг дор бүр нь залруулан ажиллаж байна.

2.8 ЗУУХ УСТГАЛЫН КОМПАНИЙД ХЯНАЛТ ХИЙСЭН БАЙДАЛ

Зуух устгалын чиглэлээр хамтран ажиллах компани/хуулийн этгээдийг сонгх зорилгоор ТҮН-ээс судалгаа хийж, өмнө нь Мянганы сорилын Сангийн зуухны хөтөлбөрт оролцож байсан компаниудад урилга илгээсэн. Энэ үйлчилгээг үзүүлэх сонирхолтойгоо илэрхийлж дараах компаниуд хүсэлтээ ирүүлэн

- Эгэл тансаг
- Тэнгэрлэг анд
- Блиссинг ХХК

Ирүүлсэн танилцуулга, хийж гүйцэтгэж байсан ажлын туршлага, хүн хүчиний нөөц, ажлын байр зэргийг шалгаж үзсэний үндсэн дээр УБЦАТ нь "Эгэл Тансаг" ХХК-ныг сонгож "Хуучин зуух устгах" ажил гүйцэтгэх №05/2013 тоот гэрээг 2013 оны 10-р сарын 7-ны өдөр байгуулсан.

холбогдох мэдээллийг олж авсан. Эзгүй байсан, гэртээ оруулаагүй, нүүсэн зэрэг шалтгаантай айл өрхүүдэд давтан хяналт хийх үргийг ЧХБ-т өгсөн. Зуухаа бусадтай сольсон, зарсан, амбаар грашд суурилуулсан гэх айл өрхөд авах арга хэмжээг даруй тодорхойлж, журам боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хэрэглэгчтэй холбоотой 423 зөрчлийг шалтгаан тус бүрээр нь ангилж үзвэл:

Тайлангийн хугацаанд "Эгэл Тансаг" ХХК хуучин зуух устгалын ажлын тайланг 3 удаа ТҮН-д ирүүлсэн. ТҮН-ээс 8 удаа зуух устгалын ажлын явцыг хянасан. Эгэл Тансаг ХХК-тай 2 долоо хоног тутамд хуучин зуух устгах ажлын явцын талаар ээлжит уулзалтыг зохион байгуулсан. Мөн УБЦАТ-ийн хүрээнд хамтран ажиллаж байгаа "Сэлэнгэ констракшн" ХХК, "Роял Өүүшн" ХХК, "Их Тэнгэрийн Хүч" ХХК-иудын дэргэд Хасбанкнаас байрлуулсан хуучин зуух хүлээн авах цэгүүдийн үйл ажиллагааг тус бүр 3 удаа очиж шалгасан.

Хуучин зуух устгалын ажлын явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлийг 2 долоо хоног тутам зохион байгуулагддаг оролцогч талуудын хурал дээр хэлэлцэж ирлээ.

ТҮН-ээс тавьсан удаа хяналтын үр дүнд "Эгэл Тансаг" ХХК нь хуучин зуух устгалын цэгийн хадгалалт, хамгаалалт, тэдгээрт тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2 ширхэг хяналтын камер, 2 ширхэг гэрэлтүүлгийн проекторыг шинээр суурилуулж ажиллах хүчиний тоог нэмэгдүүлсэн ба бүртгэлийн системийг сайжруулж хүлээн авсан, устгалд оруулсан хуучин зуухны журналыг хөтөлж, өдөр тутмын тэмдэглгээг хийж хэвшэн.

Зураг №27. Хуучин зуухыг зуух устгалын цэгт буулгаж буй байдал



Зураг №28. Хуучин зуухны эд ангийг эвдсэн байдал



Зураг №29. Хуучин зууханд тэмдэглэгээ хийсэн байдал



Зураг №30. Ачилт хийж байгаа байдал



Үр дүн:

"Эгэл Тансаг" ХХК нь 2013 оны 10-р сараас 2013 оны 12-р сарын 30-ны хооронд нийт 14685 ширхэг зуухыг хуучин зуух хүлээн авах З цэгээс өөрийн хуучин зуух устах цэгт хүлээн авч, 7092 ширхэг зуухыг устгасан байна. Үлдэгдэл 7593 ширхэг хуучин зуухыг устгалын цэгт татан аваад байна. Зуух устгалын компани хуучин зуухыг эвдэж, дахин ашиглах боломжгүй болгож Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хаягдал төмөр хүлээн авах цэгт тушаасан.

Дүгнэлт:

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хаягдал төмөр хүлээн авах хуваарьт тохируулахын тулд, эвдэгдсэн хуучин зуухыг тээвэрлэх, тушаах үйл явц хоцрогдолтой байсан нь орлогоороо зардлаа нөхөхөөр гэрээ байгуулсан "Эгэл тансаг" ХХК-ийг санхүүгийн хувьд хүнд байдалд оруулж байв. Энэ асуудлыг шийдэхийн тулд УБ-т үйл ажиллагаа явуулдаг, хаягдал төмөр хүлээн авдаг цэгүүдэд 1-2 удаагийн ачилтыг тушаах зөвшөөрлийг ТУН-ээс олгож байв.

2.9 ТӨВСЛИЙН ЗОХИЦУУПАЛТ**2.9.1 АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО**

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг нэгдмэл удирдлагаар хангах хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаагийн хэрээр энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалт улам сайжирч байна.

Гол зохицуулагч нь Монгол улсын Ерөнхий сайдар удирдуулсан "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо" юм.

Энэхүү хорооны бүрэлдэхүүнд УИХ, Засгийн газар, харьяа яамд, НЭДТГ-ын болон бусад албан тушаалтууд багтдаг. Тухайлбал Ерөнхийлөгчийн зөвлөх, Их хурлын даргын зөвлөх, Сангийн яам, Эрчим хүчний яам, Байгаль орчин ногоон хөгжлийн яам, Уул уурхайн яам, Зам тээврийн яамны төлөөллиүүд, Улаанбаатар хотын Засаг дарга, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар гэх мэт. АББҮХ агаарын бохирдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бүхий л байгууллага, төсөл хөтөлбөрүүд ажлаа тайлагнан, зорилго чиглэлээ ярилцаж, авах арга хэмжээгээ тодорхойлсоор ирсэн.

Зураг №31. Үндэсний хорооны хуралдааны хэсгээс



2.9.2 УДИРДАХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ДЭМЖЛЭГ

Зураг №32. УБЦАТ -ийн нээлтийн үеэр



Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хувь нэмрээ оруулж байгаа УБЦАТ-ийн үйл ажиллагааг удирдах дээд байгууллагууд, оролцогч талууд, иргэд олон нийт бүх талаар дэмжиж ирсэн.

УБЦАТ-ийн зуухны хөтөлбөрийг эхлүүлэх нээлтийн ажиллагааг 2013 оны 9 сарын 15-ны өдөр зохион байгуулсан ба энэхүү арга хэмжээнд "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга П.Цагаан, Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайд С.Оюун, Дэлхийн банкны суурин төлөөлөгч Кароли Гейверс, НИТХ-ын дарга Д.Баттулга болон бусад албаны хүмүүс оролцсон юм.

2013 оны 9-р сарын 9-ний өдөр нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын 92 хорооны 800 хэсгийн ахлагчтай уулзалт зохион байгуулж, УБЦАТ-ийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, өмнөх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад гарсан хүндрэл бэрхшээл, хэсгийн ахлагчдын оролцоо, санал сэтгэгдлийг сонсов. Энэхүү арга хэмжээнд НЭД Э.Бат-Үүл оролцож нийслэлийн утааг бууруулах хүн бүрийн оролцоо, хичээл зүтгэл хэрэгтэй байгааг онцлов.

Зураг №33. Хэсгийн ахлагч нарын нэгдсэн зөвлөгөөны үеэр.



УИХ-ийн гишүүн
Л.Эрдэнэчимэг, БОНХ-ийн яамны сайд С.Оюун болон бусад албаны хүмүүсийн хамт УБЦАТ-ийн хүрээнд үйл ажиллагаа нь сэргэж хэвийн ажиллаж байгаа “Зуухны утаа ялгаруулалт үр ашгийг турших лаборатори”-ийн байдалтай газар дээр нь танилцлаа. Энэ үеэр бүрэн шаталттай зууханд тавигдах техникийн болон чанарын шалгуур үзүүлэлт, туршилт хийдэг арга аргачлал, хөнгөлөлттэй үнээр борлуулагдах эрх авсан 4 зуухны талаарх болон хэрэглэгчидтэй холбоотой мэдээллийг авч гадаадын болон дотоодын зөвлөхүүд, мэргэжилтнүүдтэй уулзаж санал солилцов.

Зураг №34. УБЦАТ-ийн үйл ажиллагаатай танилцав.



2.9.3 МЭДЭЭЛЛИЙН БААЗ ҮҮСГЭХ, УЯЛДАА ХОЛБОOG ХАНГАХ

Уб хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Засгийн газар болон хандивлагчдийн хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдтэй холбогдсон мэдээллийг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, мэдээллийн сан байгуулах, мониторингийн тогтолцообий болгох үүрэг бүхий 2 зохицуулагчийг УБЦАТ-тэслээс санхүүжүүлэн НЭДТГ-т ажиллууллаа. Энэхүү мэдээллийн баазыг бий болгож, шийдвэр гаргах түвшний удирдлагуудад хүргүүлснээр байгууллагуудын уялдаа холбоо сайжрах, хөрөнгийн давхардлыг бууруулах, хөрөнгийг үр ашигтай зүйлд зарцуулах зөв шийдвэр гаргах зэрэгт тус нэмэр болох юм.

2.10 ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ-ШИНЖИЛГЭЭ

2.10.1 ДЭЛХИЙН БАНКНЫ ХЯНАЛТ

“Улаанбаатар-Цэвэр агаар” төсөл батлагдсанаас авахуулаад өнөөг хүртэл Дэлхийн банкны хяналтын хэсэг Улаанбаатарт 9 удаа хяналгаар ирсний 3 нь 2013 онд байна.

Хяналтын зорилго нь “Улаанбаатар-Цэвэр Агаар Төсөл”-ийн (УБЦАТ) хэрэгжилтийн явцтай танилцах, заавар зөвлөмж өгөх, тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх, цаашдын бодлого, төлөвлөлт, уялдаа холбооны талаар эрх бүхий байгууллагуудтай уулзаж ярилцаад оршиж байв.

Тайлант хугацаанд хяналтын баг ажиллахдаа дараах асуудлыг шийдвэрлэхэд НЭДТГ-т болон ТҮН-д туслах дэмжлэг үзүүлсэн.

- Засгийн газрын тусгай сан-Цэвэр агаарын сантай харилцан ойлголцлын санамж бичиг зурах
- Зуухны лабораторийн эзэмшилийн асуудлыг шийдвэрлэх
- Шалгуур үзүүлэлт хангасан зуухыг турших, үр дүнг боловсруулах
- Зуух борлуулах цэгийн үйл ажиллагааг хариуцах Хас банктай хамтран ажиллах хэлэлцээр хийх
- Зуух ханган нийлүүлэгчидтэй зуухны үнийг хэлэлцэн эцэслэх
- Дэлхийн банк болон ЦАС-аас гарах татаасын хэмжээг тогтоох

Зураг № 35. Дэлхийн банкнаас төслийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа нь



Мөн тайлант хугацаанд Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газрын худалдан авах ажиллагааны болон санхүүгийн мэргэжилтнүүд УБЦАТ-ийн хэрэгжилтэд тус бүр 2 удаа хяналт хийж, тайланг бичиж ирүүлсэн.


2.10.2 ТӨСЛИЙГ УДИРДАХ ХОРООНЫ ХЯНАЛТ

Тайлант хугацаанд Төслийг удирдах хорооны гишүүд төслийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцав.

Зуух борлуулах 25 цэгүүдээс 3 цэгийг сонгон авч үйл ажиллагаатай танилцаж хүндэрэл бэрхшээлийг

сонсов. Мөн зуухны утаа ялгаруулалт үр ашгийг туршил лабораторийн үйл ажиллагаанд 2 удаа хяналт хийсэн. Зуух устгалын цэг, зуух түгээх борлуулах механизмтай танилцаж, зөвлөхийн 4 гэрээний явцыг танилцуулсан илтгэлийг сонсов.

Зураг №36. Төслийг удирдах хорооны гишүүд хяналт хийж байгаа нь



2.10.3 ЗУУХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ-ЧАНАРТ ХИЙСЭН ХЯНАЛТ

УБЦАТ-ийн хүрээнд, гэр хорооллын айл өрхүүдэд татаастайгаар олгогдох зуух нь “Зуухны утаа ялгаруулалт, үр ашгийг турших лаборатори”-ийн туршилтыг давж, техникийн шалгуур үзүүлэлтийг хангахаас гадна зуухны үйлдвэрлэл болон ханган нийлүүлэлтэд тавигдах шалгуур үзүүлэлтийг давхар хангаж байх ёстой.

Иймээс хяналт, шалгалт хийх багийг томилсон ба дотоодын бүх зуух үйлдвэрлэгчдийн ажлын байраар орсон. Гадаадын үйлдвэрлэгчдээс зуух нь тэнцэн Туркийн 2, Хятадын 1 үйлдвэрлэгчийн ажлын байрыг газар дээр нь шалгасан. Үйлдвэрлэгч/Ханган нийлүүлэгчид дараах шаардлагыг тавьсан болно.



Үүнд:

- Өдөрт үйлдвэрлэх хүчин чадал дотоодын компанийд 100 гадаадын компанийд 200 зуух
- Ажлын байранд тавигдах аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэх
- Чанарын дотоодын хяналтын системтэй эсэх
- Шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон эсэх
- Олон улсын болон Монгол улсын стандартыг хангаж байгаа эсэх

2.10.4 ТҮН-ИЙН ДОТООД ХЯНАЛТ

Төслийг амжилттай хэрэгжүүлэх, хүлээгдэж байгаа үр дүнд хүрэхийн тулд ТҮН-ийн дотоодын хяналт шинжилгээ үнэлгээг хийх нь чухал юм. Иймээс тайлант хугацаанд дараах чиглэлээр хяналт үнэлгээг хийв.

Зуухны хөтөлбөрийн хяналт

(а) зуух борлуулалтын цэгүүдийн үйл ажиллагаанд тавих хяналт: Энэ ажлын хүрээнд ПР-ийн ажилтнууд иргэдээд хангалттай холбоотой иргэдээс ирсэн гомдолыг шалгах, 4 төрлийн зуухыг танилцуулахдаа шударга, тэгш байдлыг хангаж байгаа эсэх, зуух борлуулалтын цэг нь байршилийн хувьд болон үйлчилгээ үзүүлэхэд тохирч байгаа эсэх зэргийг нягтлан шалгаж байв. Энэ ажлын хүрээнд нийт 350 гаруй удаагийн шалгалт хийсэн байна.

Зураг №37. Зуухны үйлдвэрлэлт, чанарт хяналт хийв



б) Чанарын хяналтын багийн үйл ажиллагаанд тавих хяналт: Зуух борлуулалтын цэгүүдээс худалдан авсан баталгаат зуухуудыг газар дээр нь шалгаж үзэх зорилго бүхий чанарын хяналтын багийн үйл ажиллагааг үе үе шалгах. Энэ ажлын хүрээнд хэрэглэгч нь зуухаа гэрээнд заасан хаяган дээр хэрэглэж байгаа эсэх, зөв галлах зааварчилгааг ойлгосон эсэх, зуухыг аюулгүй ашиглах тал дээр сургалт авсан эсэх, зуухны чанар нь хэрэглэгчийн сэтгэлд нийцэж байгаа эсэхийг шалгах бөгөөд энэхүү шалгалтыг 2 долоо хоногт нэг удаа хийдэг.

(в) зуух устгалын компанийн үйл ажиллагаанд тавих хяналт. Энэ ажлын хүрээнд хуучин зуухыг хэрхэн хүлээн авч, бүртгэж байгаа байдал, устгалын цэг дээрх хадгалалт, хамгаалалтын байдал, устгалын чанар, тээвэрлэлт, хургэлтийн байдал зэрэгт сард нэг удаа хяналт хийв.

(г) Зуух нийлүүлэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналт. Энэ ажлын хүрээнд зуух нийлүүлэгчид нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөний дагуу ханган нийлүүлэх үйл ажиллагааг явуулж байгаа эсэх, зуухны түгээлт, суурилуулалттай холбоотой хэрэглэгчдийн саналыг барагдуулж байгаа эсэх, зуухны чанар, засвар

үйлчилгээний хяналтыг хэрхэн хийж байгааг үе үе хянаж байв.

Үүнээс гадна зуухыг ус бороо, чийгнээс хамгаалагдсан, галын аюулгүй зориулалтын сав, агуулахад хадгалж байгаа эсхэд хяналт хийж байв.

Зураг №38. Агуулах-Роял Θүүн ХХК Зураг



№39. Агуулах-Их Тэнгэрийн Хүч ХХК



Зураг №40. Агуулах-Сэлэнгэ Констракшн ХХК



2.10.5 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮДЭД ТАВИХ ХЯНАЛТ

Дунд шатанд авах арга хэмжээний бэлтгэлийн хангах зорилгоор УБЦАТ-ийн хүрээнд дараах ТЭЗҮ шалгаруулах болон стратегийн баримт бичгийг боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд сонгон шалгуурах үйл ажиллагааг амжилттай дуусган, гэрээг байгуулан, зөвлөхийн үйлчилгээг эхлүүлээд байна. Үүнд:

- Улаанбаатар хотын ногоон байгууламжийн хөрөнгө оруулалтын ТЭЗҮ-Энэ зөвлөх үйлчилгээний гэрээ 2013 оны 5 сарын 31-нд байгуулагдсан бөгөөд Францын Асконит компани болон Монголын Гео-экологийн хүрээлэнгийн

түншлэл зөвлөхийн үйлчилгээг үзүүлж байна. Зөвлөхийн үйл ажиллагааг чиглэл, удирдамжаар хангах, дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилго бүхий ажлын хэсэг Засаг даргын захирамжаар байгуулагдсан бөгөөд даргаар нь Засаг даргын экологи ногоон хөгжлийн асуудал эрхэлсэн орлогч ажилладаг. ТҮН, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газартай хамтарч зөвлөхийн үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна.

- Цахилгаан станцуудын яндангийн утаанаас болон үнсэн сангаас ялгарч байгаа тоос тоосонцрыг бууруулах хөрөнгө оруулалтын ТЭЗҮ-Энэ зөвлөх

- үйлчилгээний гэрээг Швейцарийн Эс Жи Эс компанийтай 2013 оны 9-р сарын 16 нд байгуулсан бөгөөд Дулааны цахилгаан станц 2,3 ба 4, Эрчим хүчний яамны стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэс зэрэгтэй хамтран үйл ажиллагааг хянан ажиллаж байна.
- Төвлөрсөн дулаан хангамжийг сайжруулах ТЭЗҮ- Төслийг удирдах нэгж нь энэ зөвлөх үйлчилгээний гэрээг Францын Сеурика болон Энэтхэгийн ДЕСЛ компанийн түншлэлтэй 2013 оны 9-р сарын 23-нд байгуулсан бөгөөд Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаалаар ажлын хэсгийг байгуулахаар хэлэлцээд байна. Хяналтыг Захирагчийн ажлын албаны инженерийн байгууламжийн хэлтэс, Эрчим хүчний яамны стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэс зэрэгтэй хамтран хийж байна.
 - Иргэдийн төлбөрийн чадварт нийцэн орон сууцны стратеги боловсруулах зөвлөхийн үйлчилгээний гэрээг АНУ-ын Эффордейбл хаусинг институттэй 2013 оны 9-р сарын 6-нд байгуулсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Хяналтыг НЭДТГ-ын стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэстэй хамтран хийж байна.

2.11 ХУДАЛДАН АВАЛТЫН ҮЙЛ ЯВЦ, ҮР ДҮН

“Улаанбаатар-цэвэр агаар” төслийн хүрээнд зохион байгуулагдаххудалдан авах ажиллагаанд дагаж мөрдөгдөх заавар, журмыг төслийн гэрээний болон үнэлгээний баримт бичигт нарийвчлан зааж өгсөн байдаг. Гол баримтлах баримт бичиг нь Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-ны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-ийнхөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд мөрдөх 2011 оны 1-р сард шинэчлэн найруулсан журам юм.

Түүнчлэн дотоодын нээлттэй сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хэрэв ДБ-ний “Дотоодын нээлттэй сонгон шалгаруулалт”-ын заалт журам нь Монгол улсын төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалттай нийцж байвал энэ хуулийн дүрэм журмыг дагаж мөрдөнө гэж заасан.

Хүснэгт №6. УБЦАТ-ийн худалдан авах ажиллагааны арга, босто
үнэ, Дэлхийн банкнаас урьдчилж хийх хяналт

	i. Ажил	ii. Бараа	iii. Зөвлөхийн үйлчилгээ
(a)	ДСШ:< USD 3,000,000;	(a) ДСШ:< USD 300,000; (b) Харьцуулалт:< USD 200,000;	(a) Хосолимол арга: >=USD 200,000; (b) Зөвлөхийн мэрэжийн ур чадварт түлгүүрласан арга:<USD200,000;
ХАА-ны арга/ шардлагага		(b) Харьцуулалт:< USD 100,000; (c) Бага үнийн саналтайг сонгох арга. Зөвлөх шалгаруулах журмын 3.6-р заалтад нийцэн бүх гэрээнүүд болон ТХН-ийн санхүүгийн данс тооцоог хянах аудитын бүх гэрээнүүд, гэрээний үнээс үл хамааран;	(c) Бага үнийн саналтайг сонгох арга. Зөвлөх шалгаруулах журмын 3.6-р заалтад нийцэн бүх гэрээнүүд болон ТХН-ийн санхүүгийн данс тооцоог хянах аудитын бүх гэрээнүүд, гэрээний үнээс үл хамааран;
		(d) Бие даасан зөвлөх: Зөвлөх шалгаруулах журмын 5.1-5.6-р заалтын шаардлагад нийцэн гэрээнүүд;	(d) Бие даасан зөвлөх: Зөвлөх шалгаруулах журмын 5.1-5.6-р заалтын шаардлагад нийцэн гэрээнүүд;
		(e) Нэг эх үүсвэрээс сонгох: Зөвлөх шалгаруулах журмын 3.8-3.11-р заалтын шаардлагад нийцэн гэрээнүүд;	(e) Нэг эх үүсвэрээс сонгох: Зөвлөх шалгаруулах журмын 3.8-3.11-р заалтын шаардлагад нийцэн гэрээнүүд;
		(f) Нэг эх үүсвэр (бие даасан зөвлөх): Зөвлөх шалгаруулах журмын 5.6-р заалтын шаардлагад нийцэн гэрээнүүд;	(f) Нэг эх үүсвэр (бие даасан зөвлөх): Зөвлөх шалгаруулах журмын 5.6-р заалтын шаардлагад нийцэн гэрээнүүд;
		(g) Зөвхөн доодын зөвлөхүүдээс бурдсан хураангуй жагсаалт: <USD100,000.	(g) Зөвхөн доодын зөвлөхүүдээс бурдсан хураангуй жагсаалт: <USD100,000.
i. Ажил	ii. Бараа	iii. Зөвлөхийн үйлчилгээ	
		(a) ДСШ-ын хамгийн анхны 2 гэрээ, үнээс үл хамааран;	(a) ДСШ-ийн хамгийн анхны 2 гэрээ, үнээс үл хамааран;
Урьдчилсан хяналт	(b) Бүх гэрээнүүд>= USD500,000;	(b) Бүх гэрээ=> USD200,000;	(b) Бүх гэрээ=> USD100,000;
	(c) Харьцуулалт: Доод тал нь 3 үнийн санал авах боломжгүй тохиолдолд.	(c) Харьцуулалт: Доод тал нь 3 үнийн санал авах боломжгүй тохиолдолд.	(c) Бие даасан зөвлөх: зөвхөн онцгой нөхцөлд;
			(d) Бүх НЭҮС;
			(e) НЭҮС (бие даасан зөвлөх): >=USD20,000.

2013 онд Нийслэлийн Засаг даргын захирамжаар 5 үнэлгээний хороо байгуулагдсан.

БҮЛЭГ 2

Хүснэгт №7: Нийслэлийн Засаг даргын захирамж

Д/д	Захирамжийн дугаар, огноо	Утга	Биелэлт
1	2013.01.10 Дугаар А/19	Үнэлгээний хорооны дарыг өөрчлөх тухай /Улаанбаатар хотын ногоон байгууламжид хөрөнгө оруулалт хийх ТЭЗҮ, CPLG-01 гэрээт ажлыг гүйцэтгэх зөвлөх компанийн шалгаруулах/	Зөвлөх компани шалгарсан.
2	2013.01.23 Дугаар А/59	Үнэлгээний хороо байгуулах тухай /УБ хотын төвлөрсөн дулаан хангамжийг сайжруулах ТЭЗҮ, CDHS-01 гэрээт ажил, УБ хотын дулааны цахилгаан станцуудын утса ялгаруулалт, УСНСН санний дэдээмттэй тоос тоосон цорыг бууруулах ТЭЗҮ, СРАР-01 гэрээт ажлын зөвлөх компаниудыг сонгон шалгаруулах/	Гэрээ тус бүрийн зөвлөх компаниуд шалгарсан.
3	2013.01.29 Дугаар А/69	Захирамжид өөрчлөлт оруулах тухай /2012.02.02-ны өдрийн А/56 захирамж, 2012.07.21-ний өдрийн А/507 тоот захирамжид тус бүр өөрчлөлт оруулах.	Зөвлөх компани шалгарсан.
4	2013.07.17 Дугаар А/660	Үнэлгээний хороо байгуулах тухай /Зуухны утса ялгарал, үр ашгийг турших лаборатори болон зуух боловсронгуй болгох цехийн уйл ажиллагааг өргөтгэн шинэчлэхэд шаардлагдах тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах/	Ханган нийлүүлэгч шалгарсан.
5	2013.09.18 Дугаар А/883	Үнэлгээний хороо байгуулах тухай /Гэр хорооглын айл өрхөд ханган нийлүүлэгдэх бүрэн шаталттай зуухны чанар болон ханган нийлүүлэгч, хэрэлгэлт талтуудын гэрээний биеэлгэд хяналт тавих CSVC-01 гэрээт ажлын зөвлөх компанийн сонгон шалгаруулах/	Зөвлөх байгууллагыг сонгосон.
Хүснэгт №8 2013 онд байгуулагдсан гэрээнүүд			
Д/д	Гэрээний дугаар Гэрээний нэр	ХАА-ны арга байгуулсан отноо	Зөвлөх/ханган нийлүүлэгчийн нэр байдал/үргэлжлэх хугацаа
1	CITA-01: Зуухны утса ялгаруулалт, үр дунт турших лаборатори болон зуух боловсронгуй болгох цехийн уйл ажиллагааг хөгжүүлж, ажилтнуудыг чадавхижуулах зөвлөх үйлчилгээ	Хосолмол арга 2013.01.18	Мон-Энэрги Консалт ХХК /Монгол/
2	CPLG-01: Улаанбаатар хотын ногоон байгууламжийн хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгаа	Хосолмол арга 2013.05.13	Асконгт Консалтантс /Франц/, туслан гүйцэтгэгчийн хамт шатанд /2 жил

Д/Д	Гэрээний дугаар Гэрээний нэр	ХАА-ны арга	Гэрээ байгуулсан оюу	Зөвлөх/ханган ниийгүүлэгчийн нэр	Хэрэгжилтийн байдал/үртэлжлэх хугацаа
3	СРАР-01: Улаанбаатар хотын ТЭЦ-үүдийн (2,3,4-р цахилгаан станц) ячдагийн угаагарап, үнсэн саннийн дэдээмтгийн тоосонцорын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөхийн үйлчилгээ	Хосолмол арга	2013.09.16	ЭсжиЭс Сосиете Женерале де Сурвейпланс ЭСЭЙ компани/ Швейцар/	Хэрэгжилтийн шатанд/ 8 сар
4	CDHS-01: Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийг сайжруулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөхийн үйлчилгээ	Хосолмол арга	2013.09.23	Сеурека/ Франц/, Десп/ Энэтхэг/ түншлэл шатанд/ 1 жил	Хэрэгжилтийн шатанд/ 1 жил
5	САНС-01: Улаанбаатар хотын боломжийн өртөгтэй орон сууцны стратеги боловсруулах	Хосолмол арга	2013.09.05	Эффорддэйбл Хаусинг Институт/АНУ/	Хэрэгжилтийн шатанд/ 9 сар
6	СРАС-01: Төслийн олон нийтэй харилцах Пи Ар-ын зөвлөх үйлчилгээ	Чанарын арга	2013.06.10	Брайктрау Пи Ар ХХК, Опилви Габлик Резишикс ворлдвайд / компанийн түншлэл /	Хэрэгжилтийн шатанд/ 1 жил
7	СЛТА-02: Зуухны түршилтын лабораторийн тоног төхөөрөмжийн үргэлжлэд, хянайлт тавих зөвлөх	Бие даасан зөвлөх	2013.05.24	Кристин Лембертон- Пигот	Хэрэгжилтийн шатанд/ 70 хоног
8	CSVС-01: Чанарын баталгаажуултын зөвлөх үйлчилгээ	Чанарын арга	2013.11.13	Ирээдүйн гарц ТББ / Монгол/	Хэрэгжилтийн шатанд/ 1 жил
9	CHWS-01: Ханан пишшинд зуухыг агуулж угтрах зөвлөх	Бие даасан зөвлөх	2013.08.21	П.Шаравчям	2.5 сар
10	GLEQ-01: Зуухны ялгаруулалт, Үр дүнг турших лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж ханган нийлүүлэх	Харьцуулалтын арга	2013.10.21	Сүлжээ ХХК /Монгол/	2 сар

ДУГНЭЛТ

2013 онд "Улаанбаатар-цэвэр агаар" төслийн худалдан авах ажиллагааны гол гол томоохон ажлуудыг амжилттай зохион байгуулж, зөвлөх үйлчилгээг үйл ажиллагаанд бүрэн оруулав.

2.12 ТАТААСЫН ТӨЛБӨР, САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦ

2.12.1 БҮРЭН ШАТАЛТТАЙ САЙЖРУУЛСАН ЗУУХНЫ ТАТААС


2013-2014 оны халаалтын улиралд УБЦАТ-ийн хүрээнд борлуулвал зохих 45000 бүрэн шаталттай зуухнаас 2013 онд багтаан 60-70% -ийг нь борлуулах төлөвлөгөөтэйгээр ажилласан.

2013 оны 12-р сарын 31 гэхэд зуухны гэрээ хийсэн айл өрхийн тоо нь 24361-т хурч, 15997 ширхэг зуухыг суурилуулалт хийсэн буюу айл өрхөд олгосон. Нийт Улаанбаатар хотын зургаан дүүргийн 92 хороог хамарсан борлуулалтын 25 цэгээр дамжуулан борлуулалтыг хийсэн.

Тайлант хугацаанд 11425 айл өрхийн татаасын материалыг хянан үзээд 11424 өрхийн татаасын төлбөрийг Улаанбаатар-Цэвэр агаар төсөл, Цэвэр агаарын сангаас санхүүжүүлсэн.


2013 оны 11-р сарын 18-ны өдрөөс зуухны татаасыг олгож эхэлсэн бөгөөд нийт 8 удаагийн санхүүжилтээр 1,435,587.20 ам.доллартай тэнцэх 2,370,895,513.89 төгрөгийн татаасыг олгосон байна.

Зураг №41. Татаасын санхүүжилт хийх ерөнхий схем




Зуухны тоо болон санхүүжилтыг компани тус бүрээр харуулбал:

Зураг №42 Татаас олгосон зуухны тоо компани тус бүрээр



Зураг №43. Татаасын санхүүжилт (ам.доллараар) компани тус бүрээр



2.12.2 ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН КОМПАНИЙН АЖЛУУД, ТЭДГЭЭРИН САНХҮҮЖИЛТ

Олон нийтэд чиглэсэн компанийт ажлыг зохион байгуулах, үүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төслийн удирдлагын төлбөрөөс гаргахаар гэрээний баримт бичигт тусгагдсаны дагуу ПР-ийн зөвлөх багтай хамтран агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр болон бүрэн шаталттай зуухны талаар зөв ойлголт өгөх, зуух солих хөтөлбөрийг дэмжих олон талт арга хэмжээний төлөвлөгөөг гарган Дэлхийн банкинд танилцуулж хөрөнгө зарцуулах зөвшөөрөл авсан.

Хасбанкнаас зуух борлуулах цэг(байнгын 18, явуулын 7)-т ажиллах 25 гэрээний ажилтан, түгээлт, сууринтуулалтын хяналт хийх 25 ажилтан, хуучин зуух

хүлээлцэх 4 ажилтан, 25 борлуулах цэгт ашиглах компьютер, принтер зэргийг хариуцан ажиллаж байсан бол ТҮН-ээс энэхүү борлуулалтын цэгүүд дээр байршуулах зар сурталчилгааны материал, зуухнуудын танилцуулга, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, борлуулалтын төвийн байршил, ажиллах цагийн хуваарь, хөтөлбөрт хамрагдах өрхөд тавигдах шаардлагууд, айл өрхөд тараах материал, брошур, гарын авлага зэргийг хэвлүүлэх, олшруулах, сууринтуулалтын хяналт хийж байгаа болон чанарын хяналт хийж байгаа 30-аад ажилтнуудад зориулан УБЦАТ-ийн лого бүхий хантаазнуудыг нэг маягаар захиалан хийлгэлээ.

Мөн нийслэлийн хэвлэлийн хүрээлэнтэй хамтран 20 гаруй сэтгүүлчийн нэгдсэн уулзалтыг зохион байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллахад уриалсан. Нийт 92 хорооны 800 хэсгийн ахлагчтай хийх уулзалт мөн 6 дүүргийн хороо, хэсгийн ахлагч нартай хийсэн цуврал уулзалт зэргийг зохион байгуулав.

Телевиз, радио, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, хэлэлцүүлэг, шууд ярилцлага, зөв галлагааны талаархи 4 төрлийн шторк, баримтат кино зэргийг хийж, хэд хэдэн ТВ радиотой гэрээ байгуулан цацсан.

Тайлант хугацаанд 2013 онд зар сурталчилгааны ажилд зориулж нийт 30,660.54 ам.долларын санхүүжилт хийсэн байна.

2.12.3 ТЭЗҮ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

Тайлант хугацаанд 4 чиглэлээр ТЭЗҮ боловсруулах зөвлөх компаниутдтай гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн ба ажлын явц эхлэлийн шатандаа байгаа тул санхүүжилт мөн 10-30%-тэй байна.

2.12.4 ДУГНЭЛТ:

Зуухны татаасыг олгохдоо 2 үндсэн баримтыг үндэслэхээр үйл ажиллагааны гарын авлагад тусгасан. 1-рт: Хас банкнаас ирсэн татаасын материал. Энд зуух суурилагдсан болохыг нотолсон бүх мэдээлэл байна. (Хэрэглэгчийн нэр, хаяг, зуухны серийн дугаар, хэрэглэгчийн GPS хаяг, иргэний үнэмлэхийн хуулбар) 2-рт: Хяналтын багийн шалгалтаар зөрчилгүй болох нь нотлогдсон айл өрхийн жагсаалт.

Гэвч бодит байдал дээр хяналтын багийн шалгалт нь гэрээнд болон ажлын удирдамжид заагдсан хугацаанд амжиж хийгдэхгүй байгаагаас төлбөр хойшлох, хугацаа алдах зэрэг асуудал гарч байв. Нийлүүлэгч компаниудын санхүүгийн чадамж сүл, эргэлтийн хөрөнгө байхгүй байдал нь үүнд бас нөлөөлж байв. Нэг талаас борлуулах, түгээх, суурилуулах механизмыг тасалдуулахгүй байх, нөгөө талаас нийлүүлэгч компаниудыг санхүүгийн байдлаас зэргээс хамаарч зарим тохиолдолд ЦАС-тай зөвшилцөний дагуу төлбөрийг зөвхөн нэг талын шалгалт (Хас банк)-ыг үндэслэн хийж байсан ба хоёр дахь шалгалтыг нөхөж хийж тохиолдол гарч байв.

БҮЛЭГ 3

3.1 2013 ОНЫ ЗОРИЛТУУД

- (I) Бүрэн шаталттай сайжруулсан зуухны үр ашгийг иргэдэд ойлгуулах, зуухыг, борлуулах, суурилуулах арга замыг тайлбарлах, зааврын дагуу зөв галлах арга барилдиргэдийг сургах
- (II) Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй

хөтөлбөр, төслүүдийн мэдээ мэдээллийг системтэйгээр нэгтгэх, энэхүү мэдээллийн санг оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцаа холбоог сайжруулах зорилгоор хэрхэн ашиглах арга замыг шийдвэр гаргах түвшин, хэвлэл мэдээллийн хэрэгслэл, олон нийтэд түгээхэд оршиж байв.

Зураг № 44. Зорилтот бүлгүүд ба тэдгээрт чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны гол агуулгыг дараахи зургаар илрэхийлэв.




3.2 СТРАТЕГИ

Мэдээлэл – хамтын ажиллагааны стратегийг боловсруулж (I) мөлхөө сурталчилгаа, (II) борлуулалтын төвүүд дахь мэдээлэл, сургалт (III) нийгмийн мэдээллийн сүлжээ (IV) олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэл, (V) үзүүлэх сургалт,

нийтийн арга хэмжээ (VI) дугуй ширээний ярилцлага, (VII) ажлын хэсгүүдийн форум уулзалтуудыг тогтмол зохион байгуулах замаар мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Зураг № 45. Мэдээлэл, хамтын ажиллагааны стратеги



3.3 ҮР ДҮН



38000 өрхтэй утсаар холбогдож мэдээлэл хүргэв . . .

Иргэд борлуулалтын төвүүдийн байршил, хөтөлбөрт хэрхэн хамрагдах тухай ойлголттой боллоо.

Зуух солих хөтөлбөрийг эхлүүлэхэд

- борлуулалтын төвийн байршил, ажиллах цагийг танилцуулах,
- хөтөлбөрт хамрагдах өрхөд тавигдах шаардлага,
- бэлтгэл, аюулгүй байдлыг хэрхэн баталгаажуулах тухай зааварчилгааг иргэдэд өгөх нь чухал зорилтуудын нэг байв.

Төслийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй

хөтөлбөрт хамрагдах боломжтой өрхийн жагсаалтанд багтсан иргэдтэй утсаар холбогдож дээрхи мэдээллийг өгөхийн зэрэгцээ тэмдэглэл, бүртгэлийг хийн зорилтот өрхүүдийн байршил, нэгж борлуулалтын төвд ногдох үйлчлүүлэгчийн боломжит тоог тооцон гаргасан. Утсаар холбогдох энэхүү арга хэмжээ нь хэрэглэгчдийг борлуулалтын төвтэй холбоо, хөтөлбөрт хамрагдах олон нийтийн сэдлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байсан.



72116 иргэн борлуулалтын төвөөр зочлов . . .

Зочилсон хүн бүр зуухны үр ашиг, ашиглах заавар, аюулгүй байдлын шаардлагатай танилцав.

Борлуулалтын төвүүдээр зочлох иргэдийн тоо өсч өдөрт дундажаар 348 сайжруулсан зуухыг иргэдэд татаастай үнээр борлуулсан. Төв бүрт мэдээлэл

сурталчилгааны ажилтныг тогтмол ажиллуулж зочилсон иргэд

- борлуулагдаж буй зуухны төрлүүд
- сайжруулсан зуухны дулаан ялгаруулах, хадгалах, утааг багасгах үр ашиг
- суурилуулалтын өмнөх бэлтгэл, аюулгүй байдлын шаардлага

- зуухыг арчилж хамгаалах зааварчилгаа
- чанарын хяналт
- зөв галлах горимын талаархи ойлголтой болов.



28000 иргэн үзүүлэх сургалтанд хамрагдav . . .

Сайжруулсан зууханд зөв галлагааг хийх үзүүлэн сургалтыг хийлээ.




Иргэдийн олон жил мөрдөж заншсан доороос шаталттай галлагааны горимыг өөрчлөх, хэрэглэгчдийн зан байдалд нөлөөлөх нь төслийн мэдээлэл сурталчилгааны томоохон зорилтын нэг юм.

Энэ ажлын хүрээнд хөл хөдөлгөөн ихтэй зах, худалдааны төвүүдэд сайжруулсан зуухыг хэрхэн зөв галлах зааврыг үзүүлэн, зуухны гадаргуу бүрэн халах, дулаанаа хадгалах хугацааг хэрэглэгчтэй хамт ажиглаж, цэнэг галлагааг аюулгүй байдлаар хийх арга замыг нэг бүрчлэн танилцуулав.



50 сэтгүүлч санаачлагад нэгдэв . . .

Улсын нийслэлдээ утаагүй амьдарцгаая урианд сэтгүүлчид нэгдлээ.



Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр нийслэлээс баримтлах бодлого, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар сэтгүүлчдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

Мөн арга хэмжээний үеэр баталгаатай эх үүсвэрээс мэдээлэл авах, иргэд олон нийтийн анхаарлыг агаарын бохирдлыг бууруулахад чиглүүлэн, идэвхижүүлэх зорилгоор хамтран ажиллах уриалгыг сэтгүүлчдэд тавьж зөвлөлдөв.



24480 секундын эфирийн цацалт . . .

Энгийн, хялбаршуулсан мэдээлэл, заавар, санамж зөвлөгөөг иргэдэд хүргэв.

Телевизийн эфирээр

- агаарын бохирдол нийслэлчүүдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байна вэ
- агаарын бохирдлыг бууруулахын тулд иргэд юу хийж чадах вэ
- сайжруулсан зуухыг хаанаас, хэрхэн авах вэ
- зөв галлагаа гэж юу вэ

- татаастай үнээр борлуулсан зуухны бүртгэл хяналтыг хэн, хэрхэн хийх вэ зэрэг иргэд, хэрэглэгчдэд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөөг энгийн ойлгомжтой, хялбаршуулсан хэлбэрээр бэлтгэн цацаж, нийт 413 удаагийн цацалтын төгсгөлд төсөлтэй холбогдох утас, хаягийг танилцуулсан.

Сурталчилгааны дүнд иргэдтэй холбогддог 1199, 1200, 312194 утасны хандалт идэвхижиж борлуулалтын

72 хоногт нийт 340 дуудлага, 156 өргөдлийг хүлээн авч шийдсэн.



880 хэсгийн ахлагчид чуулав . . .

Иргэдтэй хамгийн ойр ажилладаг хэсгийн ахлагчид мэдээллийг нэг дороос авлаа.



Зуух солих хөтөлбөрийн хэрэгжилт, зуухны арчлалт, ашиглалтын талаар иргэдээс ирдэг нийтлэг асуултуудад хариулт өгөх зорилгоор нийслэлийн 6 дүүргийн 880 хэсгийн ахлагчийн нэгдсэн уулзалтыг 2 удаа зохион байгуулав.

Уулзалтын дүнд хэсгийн ахлагчид төслийн талаар нэгдмэл ойлголттой болохын зэрэгцээ, зуух ханган нийлүүлж буй компаниудтай танилцаж зуухтай холбоотой санал гомдлыг хаана уламжлах талаар ойлголттой болсон.


БҮЛЭГ 4

4.1 ИРГЭДИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРТ НИЙЦСЭН ОРОН СУУЦНЫ СТРАТЕГИ

Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны стратеги,

бодлогыг боловсруулах нь зөвлөхийн үйлчилгээний гол зорилго юм.

Зураг №46. Зөвлөх үйлчилгээний төлөвлөлт



Зөвлөх нь 2013 онд (I) эхлэлийн тайланг бэлтгэж үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, арга зүйг боловсруулах (II) оролцогч талуудын дүн шинжилгээ

хийх (III) стратегийн форумыг байгуулах (IV) асуудал эрхэлсэн төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж дараах үр дүнд хүрсэн.

Хүснэгт №9. Зөвлөхөөс боловсруулсан төлөвлөгөө

Үйл ажиллагаа	Үе шат	Үр дүн
Эхлэлийн тайлан-Арга зүй, төлөвлөгөө боловсруулах	Эхлэлийн тайлан	Судалгааны арга, хандлага, зорилгоо биелүүлэх цаг хугацааны төлөвлөлтийг боловсруулах эхлэлийн тайланг бэлтгэв Дэлхийн Банк, Сангийн яам, Барилга Хот Байгуулалтын яам, Нийслэлийн засаг даргын 2 орлогч, 2 хэлтс, ТҮН-д тайланг хүргүүлэв Дэлхийн Банк, Сангийн яам, Барилга Хот Байгуулалтын яам, Нийслэл, ТҮН-с зөвлөхийн боловсруулсан арга зүйг илүү тодорхой нарийвчлах саналын албан бичгээр хүргүүлэв.
	Арга зүй, төлөвлөлтийг хэлэлцэх уулзарт	Ажлын арга зүй, төлөвлөлтийг танилцуулахаан авах зорилгоор ажлын хэсэг болон Нийслэлийн Засаг даргын хот байгуулалт, хөрөнгө оруулалт хариуцсан орлогч даргатай 4 удаагийн хэлэлцүүлэг, ярилцлагыг зохион байгуулав.
	Арга зүйн шинэчлэлт	Уулзартын дунд оролцогч талууд зөвлөхийн үйлчилгэнээс хүлээгдэж буй үр дүн, арга зүйн талаар нэгдмэл ойлголтой болов
Оролцогч талуудын дүн шинжилгээ	Жагсаалт	Санал зөвлөмжийг үндэслэн тайландаа шинэчлэлт хийж оролцогч талуудын үнэлгээ, Нийслэлийн орон сууцны төрөл ба хүн ам зүйн үнэлгээ, ЗГ-ын орон сууцкуулах хеталбэр, бодлогын дүн шинжилгээ, олон улсын туршлагаас суралцах арга зүйн нарийвчлан сайжруулав
	Үүрэг хариуцлагын давхардال	Орон сууцны салбарын оролцогч талуудыг бодлого, төлөвлөлт судалгаа гүйцэтгэл, хяналт зэрэг үйл ажиллагааны чиглэлээр ангилан бүртгэж жагсаав
Салбарын асуудлуудыг тодорхойлох	Нийлүүлэлтийн улддаа холбоо	Жагсаалтыг үндэслэн оролцогч талуудын ажил үүргийн онцлог, давхардал, орхигдсон орон зай байгаа эсэхийг дараагийн шатанд үнэлхээр төлөвлөв
Стратегийн форумыг байгуулах	Оролцогчдын жагсаалт	Газраас эхлээд орон сууцны циклийн бүхий л үе шатуудад үнэлгээ өгч, дотоод, гадаад орчны дүн шинжилгээг эхлүүлэв
	Ажлыг хэсэг	Стратегийн баримт бичгийн агуулга, түүнийг боловсруулахад хамтран ажиллах оролцогч талуудын жагсаалтыг гаргав Зөвлөхийн үйлчилгээний явц, үр дүнг эхлэлцэх, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийслэлийн засаг даргын хот байгуулалт, хөрөнгө оруулалт хариуцсан орлогч даргаар ахшуулсан ажлын хэсгийг байгуулан 14 хоног тутамд уулзарт зохион байгуулж хэвшив.

4. 2 УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ ТЭЗҮ

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийг боловсронгүй болгох ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний зорилго нь дараах байдлаар тодорхойлогдоно.

ТЭЗҮ-ийн хүрээнд нэн түрүүнд буюу 2015-2017 онд хийгдэх шаардлагатай ажлын цар хүрээг тодорхойлох явдал юм.

ТЭЗҮ дараах бүрэлдэхүүнтэй байна:

- Төвлөрсөн дулаан хангамжийн системийн ирээдүйн өсөн нэмэгдэж буй хэрэглээнд нийцэн урт хугацааны стратеги төлөвлөлт;
- Одоо ашиглагдаж буй төрийн өмчит ДЦС (348 МВт-ын дулааны станц мөн орно)-үүд болон төр хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжин баригдах ДЦС-5 -үүдүн хоорондох ажиллагааны найдвартай байдлыг (дулаанаар хангах бүсүүдийг) тодорхойлох;
- Үр дүн хүртэг байгууллагын санхүүгийн чадавхид дун шинжилгээ хийж, төслийн зардлыг хариуцах чадвартай эсэхэд үнэлэлт өгөх, тарифын түвшинд үзүүлэх нөлөөллийн талаар дүгнэлт гаргах;
- Төвлөрсөн дулаан хангамжийн салбарыг санхүү ба үйл ажиллагааны менежментийн хувьд үр дүнтэй, өндөр бүтээмжтэй тогтолцоотой болгох үүднээс дахин зохион байгуулах стратеги боловсруулах;

Зөвлөх баг нь тайлангийн хугацаанд дараахи байгууллагуудтай уулзарт хийж анхан шатны мэдээллийг цуглуванс.

Үүнд: ЭХЯ, ЭХЗГ, ДЦС, УБ хотын ЗАА, ЗАА-ны ИБХ, УБДСТӨХК, НЕТГ, НӨХГ, ОСНААУГ, ОСНААК, хувийн хэвшлийн ОСК-тай нийт 138 удаа уулзарт хийсэн.

Зөвлөх багийн үйл ажиллагааг хотын бодлого шийдвэртэй уялдуулах, заавар зөвлөмжөөр хангах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг УБ хотын ерөнхий менежер бөгөөд ЗАА-ны даргын тушаалаар байгуулсан бөгөөд энэхүү ажлын хэсэгт Эрчим хүчний яамны стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн инженерийн байгууламжийн хэлтэс, УБДС ТӨХК, ОСНААУГ болон бусад холбогдох байгууллагын төлөөлөл багтсан.

4.3 УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖ, ТАРИМАЛЖУУЛАЛТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТЭЗҮ БОЛОВСРУУЛАХ

Францын “Асконит консалтант” компани болон Монголын геоэкологийн хүрээлэнгийн түншлэл нь энэхүү зөвлөх үйлчилгээг үзүүлэх зөвлөх багаар шалгарч 2013 оны 5 сарын 31-нд гэрээ байгуулан ажиллаж байна.

Энэхүү судалгааны ажил нь дараах зорилгыг агуулсан.

а) УБ хотын тарималжуулалт, ногоон байгууламжийн төлөвлөлт, засвар арчлалт, удирдлагатай холбоотой бодлого зохицуулалт, хууль эрх зүй, дүрэм журам, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг судалж үзэн үнэлгээ дүгнэлт өгөх

б) Үлгэр жишээ болохуйц ногоон байгууламжийн загвар төсөл боловсруулах


в) Сонгон авсан загвар төслийн хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зэрэг болно.

Тайлант хугацаанд зөвлөх баг нь гарааны уулзалтыг зохион байгуулж, эхлэлийн тайланг хүлээлгэн өгсөн ба УБ хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд тусгагдсан 22 байршилаас загвар төсөл хэрэгжүүлэхдээ тохиромжтой нэг байршилыг сонгох шалгуур үзүүлэлтийг гаргаж хэлэлциүлсэн. Судалгааны үр дүнг танилцуулах семинарыг зохион байгуулж “Тасганы овоо”-г загвар төсөл хэрэгжүүлэх байршил болгохоор шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын экологи, ногоон хөгжлийн асуудал эрхэлсэн орлогч даргаар удирдуулсан ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд энэхүү ажлын хэсэг нь зөвлөхийн ажлын явц, үр дүнтэй танилцаж заавар удирдамжаар ханган ажиллаж байв.

Зураг №47. Судалгаанд хамрагдсан газрууд, үнэлсэн байдал

Preselection dated August 2nd 2013



4.4 «2,3,4-Р ЦАХИЛГААН СТАНЦУУДЫН ЯНДАНГААС БОЛОН ҮНСЭН САНГААС ЯЛГАРЧ БАЙГАА ТООСОНЦОР, ХҮХРИЙН ХИЙГ БУУРУУЛАХ ТЭЗҮ

“Улаанбаатар-Цэвэр агаар” төслийн хүрээнд цахилгаан станцууд болон үнсэн сангүүд дээр хэмжилт хийх замаар бохирдлыг тодорхойлох, хүрээлэн байгаа орчинд болон хүн амд үзүүлж болох серөг

нэлөөллийг тодорхойлох, цаашид энэхүү нэлөөллийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг гаргаж ирэх нь зөвлөх үйлчилгээний гол зорилго юм.



Зураг №48. Ажлын хэстийн хурал 2013.12.12-“Тасгыны овоо”

Энэхүү зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэхээр Швейцар улсын SGS-Societe Generale de Surveillance S.A. компани шалгарч 2013 оны 9-р гэрээ байгуулан ажиллаж байна. Тус компанийн хэмжилтийн баг болон холбогдох хүмүүс цахилгаан станцууд дээр утааны

хэмжилт хийж, үнсэн сангаас дээж аван хэмжилт хийж холбогдох мэдээллийг авсан. Тус ТЭЭҮ боловсруулах ажлын эхний тайлан гарч холбогдох газруудаас санал, шүүмжлэл авахаар хүргүүлэд байна.

Зураг № 49. SGS компанийн мэргэжилтийн 4-р цахилгаан станц дээр



Зураг №50. 2-р цахилгаан станцын үнсэн сан



5.1 ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

"Улаанбаатар-Цэвэр Агаар" Төслийн тайланг дараах хэлбэрүүдээр гаргаж ирлээ.

- 2 долоо хоног тутмын тайлан
- Улирлын тайлан
- Жилийн тайлан

2 долоо хоног тутмын явцын тайлан нь товч хэлбэртэй байдаг ба үүнд тухайн 2 долоо хоногт болж өнгөрсөн үйл явц, ололт, үр дүнг үзүүлж Дэлхийн банкны тесэл хариуцсан удирдлагуудад хүргүүлдэг.

Тайлант хугацаанд улирлын тайланг З удаа гаргасан бөгөөд энэ нь харьцангуй дэлгэрэнгүй байдааар бичигддэг.

Үйл ажиллагааны гол үзүүлэлтууд нь тайлангийн нэг хэсэг байх бөгөөд дараах шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих нь чухал юм.

- Баталгаат зууханд хамрагдаагүй үлдсэн өрхүүдийг хамруулах¹
- Тооцоолж байгаа утааны PM_{2,5} бууралтыг хангах чадавхи: өрхүүдийн галлах дадлаас хамааран утааны бууралт харилцан адилгүй байгаа тул утааны бууралтыг тооцолох арга замыг олох.
- Орчны PM₁₀ ба PM_{2,5} Агаарын бохирдлыг бууруулахаар тавьж байгаа бүх хүчин чармайлтын үр дүнд гарч байгаа ахицыг чиглэл болгон агаарын чанарт ерөнхий мониторинг хийнэ. Мэдээллийг Ус цаг уур, орчны шинжилгээний газар болон УБ хотын Агаарын чанарын албаас авсан мэдээлэл дээр үндэслэнэ.
- Бусад үзүүлэлтийг цуглувж, төслийн хэрэгжилтийн явцын тайланд оруулна.

Энэхүү тайлан нь УБЦАТ-ийн анхны "Жилийн тайлан" бөгөөд тухайн жилд тесэл хэрэгжүүлэх хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил, олж мэдсэн зүйлс, сургамжийг харуулахыг хичээв. Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг тайлант хугацаанд гарган хавсралтаар харуулав.

¹ Баталгаат зууханд нам даралтын бойлорыг оруулж болох ба тэгэхдээ зууханд нэмэлт хөнгөлөлт олгох шаардлагагүй

6.1 ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ

ТҮН-ийн хамт олон нь 2013 онд тавьсан зорилтоо амжилттай биелүүллээ. Халаалтын улиралд буюу 9-р сарын 15-аас 5-р сарын 15-ны хооронд бүрэн шаталттай зуухны хөтөлбөрт хамрагдвал зохих айл өрхийн тоог 70-80%-д хүргэн гэсэн зорилт тавьсан ба ТҮН нь 12-р сарын 31-гэхэд энэ зорилтынхоо 78%-д хүрсэн байв. Төслийн хамт олны идэвхи чармайлт хичээл зүтгэлийг оролцогч талууд өндөрөөр үнэлсэн. Тухайлбал: Дэлхийн банкны теслийн удирдагч ноён Гайлиус Драйгелис "Улаанбаатар цэвэр агаар төслийн үйл явц маш сайн байгаа бөгөөд бидний зүгээс төслийн үйл ажиллагааг бүрэн хангалттай гэж үнэлж байна. Энэхүү нарийн төвөгтэй бөгөөд чухал ач холбогдолтой төслийг хэрэгжүүлж буй Төслийг удирдах нэгжийн хамт олонд талархлаа илэрхийлье. Агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах дэд бүтцийг нийслэл хотдоо бий болгох, иргэдээс тогтвортой үйлчилгээ үзүүлэхийн төлөө хичээнгүйлэн, зөрөг сэтгэлгээтэйгээр ажиллаж буй ТҮН-ийн хамт олны хүн нэг бүртэй хамтран ажиллахад таатай байдал юм. Мөн ТҮН-ийн зүгээс шийдвэрлэх боломжгүй аливаа асуудлуудыг шийдвэрлэх болон үйл ажиллагаанд цаг тухайд нь дэмжлэг үзүүлэн чиглүүлдэг Нийслэлийн Засаг даргын байгаль орчин ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга ноён Т.Бат Эрдэнэ тэргүүтэй Төслийг удирдах хорооны гишүүдэд талархлаа илэрхийлж байна. Та бүхний дэмжлэг туслалцаа төслийн цаашдын идэвхтэй үйл ажиллагаа болон үр өгөөжид чухал ач холбогдолтой болохыг тэмдэглээ" гэжээ. Төслийг удирдах хорооны гишүүд нь оны эцсийн үр дүн хэлэлцэх хуралдаан дээр "ТҮН-ийн хамт олон нь өмнөө тавьсан зорилгоо амжилттай биелүүлсэн тул 2013 оны үйл ажиллагааг "бүрэн хангалттай гэж үнэлсүгэй" гэж онцолсон байна.

6.2 ХҮНДРЭЛ, СУРГАМЖ

Төсөл хэрэгжүүлэх явцад тулгарч байсан асуудлууд, бэрхшээлүүдийг үндсэн 3 бүлэгт хуваан үзсэн.

Иргэдтэй холбоотой хүндрэл

Иргэдийн дунд ямар нэг агаар төсөлд хамрагдаж "зуух үнэгүй шахуу авах" гэсэн сэтгэлгээ давамгайлсан байна. "Би энэ төсөлд чинь хамрагдах ёстой, яагаад ийм олон шалгуур тавьж байгаа юм бэ? гэх, эсвэл би тэр утааг чинь гаргаад, агаарыг чинь бохирдуулаад байж байя" гэсэн хандлага их байна. Мөн төслийн шалгуур хангаад бүрэн шаталттай зуух авсны дараа ашиг олох байдлаар бусдад худалдах, бэлэглэх асуудал их гарч байна.

- Бүртгэлийн системтэй холбоотой хүндрэл

Хороо дүүргээс гарган өгч байгаа мэдээллийн үнэн бодит байдал муу байна. Гаргаж өгч байгаа нээсийнхээ төлөө хариуцлага хүлээх ухамсар, чадвар муу байгаа нь зарим хороо хэсэг дээр ажиглагдаж байна. Ихэнх хороо, хэсгийн дарга нар шинэчлэгдсэн учраас шинээр ирж байгаа болон хуучин суурьшмал айл өрхөө мэдэхгүй байна. Бүртгэлгүй иргэд маш их байна.

- Нийлүүлэгчтэй холбоотой хүндрэл

Төсөл хэрэгжиж эхэлсэн эхний сард нийлүүлэгчтэй холбоотой асуудал их гарч байв. Зуухыг хүргэж өгөөд суурьлуулалгүй орхих, иргэний бичиг баримт хаяган дээрхтэй таарахгүй байхад орхиод явах, хуучин зуухыг хураан авахдаа хэрэглэж байгааг биш орлуулж өгснийг авах, зуухны дугаарыг давхардуулах, өөрийн зуухыг илүү сурталчлах, янз бүрийн амлалт өгөх, иргэдтэй зүй бусаар харьцах гэх мэт асуудлууд их гарч байв. Оролцогч талуудтай гэрээний хариуцлага тооцон ажилласны үр дүнд эхний нэг сарын дараа энэхүү зөрчил эрс буурсан байв.

6.3. ДҮГНЭЛТ

Төсөл хэрэгжүүлэх явцад дараах эрсдлүүдийг урьдчилан тооцоолж байсан. Үүнд:

- ТҮН-ийн хувьд УБЦАТ нь өмнө хэрэгжүүлж байсан төслийдээс ялгаатай, олон тооны судалгааг удирдан зохион байгуулах ур чадвар шаардсан, халаалтын олон төрлийн хэрэгслүүдээс оновчтойг сонгох ажиллагаа, олон тооны сонирхогч талуудтай харилцах гэх мэт асуудлууд гарч болзошгүй гэж үзэж байсан.
- Хэрэгжилтэд ханган нийлүүлэлтийн сүлжээний сүл байдал, хувийн хэвшлийн сонирхлыг татахуйц зах зээлгүй байдал, айл өрхийн дадал хэв маяг өөрчлөгдөхгүй байх зэрэг эрсдэл
- Төслийн хүрээнд туршигдсан халаалтын хэрэгслүүд нь лабораторийн туршилтыг давж чадахгүй байх эрсдэл
- Дэээрх эрсдлүүдийг бууруулах арга механизмуудыг урьдчилан олж харах, өмнөх төсөл хөтөлбөрийн туршлагаас аль болохоор ихээр суралцах, оролцогч талуудын хамтын ажиллагааг улам сайжруулах, мэргэжлийн баг, экспертуудээс зөвлөгөө авах зэргээр төслийн өдөр тутмын үйл ажиллагааг эрсдэл бууруулахад анхаарч ажилласны үр дүнд төсөл амжилттай хэрэгжиж эхлээд байна гэж дүгнэж байна

ХАВСРАЛТ

Хавсралт №1. Зүйхны борлуулалтын мэдээ

2013.10.07-2014.01.03

Нийт	Гэрээ хийсэн					Төлбөр төлсөн			Сууринтуулалт хийсэн			
	Өлзий	Дөл	Бекас	Нийт	Өлзий	Дөл	Бекас	Нийт	Өлзий	Дөл	Бекас	Нийт
БГ	753	1267	94	2,114	653	915	81	1,649	554	752	71	1,377
СХ	2451	5747	374	8,572	2,274	4880	357	7511	1,845	3862	310	6017
БЗ	2252	3723	357	6332	2062	3374	323	5,759	1,638	2,558	286	4482
СБ	900	1719	200	2819	744	1419	161	2317	569	1084	129	1,782
ХҮ	631	1183	52	1,866	565	1084	47	1,696	430	760	43	1233
ЧЗ	1000	1916	156	3072	837	1567	132	2,566	664	1164	114	1,942
Нийт	7987	15555	1,233	24775	7135	13262	1101	21498	5700	10180	953	16833

Хавсралт №2. Төслийн үр дүнтгийн шалтгур үзүүлэлт

Төслийн зорилго \ГЗ\

Төслийг боловсруулсан зорилго нь гэр хороооллын хэрэлгэчийг утгаа бага гаргадаг халаалтын хэрэгслээр хангах, цаашид Улаанбаатар хотод, нарийн тоосонцор РМ-ыг бууруулах дунд хугацааны арга хэмжээг хөгжлийн түншүүдэй хамтран боловсруулахад оршино

ТЭ-ЫН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	Гүйц тэл	Хэмжих нэгж	Сурь үзүүлэлт	Зорилтын нэгдсэн үнэ цэнэ** /Жилийр/				Мэдээллийн отноо\аргачла л	Мэдээллийн хариу цагч	Тодорхойлолт\Үз үүлэлтийн тайлбар\	
				Ж 1	Ж 2	Ж 3	Ж 4				
Үзүүлэлт НЭТ: Зүйжны хөгөлбөрт хамрагдан өрхийн тоо	Төлөв .Бие.	%	45000 %	5%	0%	40%	60%	8 0 %	Хагас жил	Мониторигийн ильтэл	УБЦАТ дэмжсэн халаалтыг авсан зорилтолт өрхийн тоо
Үзүүлэлт ХОЁР: Хамтрагч тулуудаас звешвэрэл авсан гол зөвлөмжүүд дунд хугацааны үйл ажиллагааны төслийнгээг боловсруулах	Төлөв .Бие.	%	24775 Батлагдсан арга хэмжээний тулвлалгэе- нүүдийн тоо	55%	0	0	4	4 4 %	Хагас жил	Мониторигийн ильтэл	УБЦАТ-өөс гарсан багц зөвлөмжүүд, авах арга хэмжээнүүдийн төслийнгээг боловсруулах
Үзүүлэлт ГУРАВ: Донорууд болон байгуулалтуды н хооронд агаарын бохирдолыг буруулах чиглэээр авч хөргжүүлж байгаа арга хэмжээнүүд	Төлөв .Бие.	Нийт жилийн тоо	1 Биел.	2	3	4	5	6	Хагас жил	Мониторигийн ильтэл	Тестийн хэрэгжилтийн хугацаанд хэрэгжкулээн зочижуулалтын механизм
Дунд хугацааны үр дун											
Дунд түвшиний үр дунгийн үзүүлэлт \Бүрэлдэхүүн хэсг нэг\ : Гэр хорхослын РМ-н бууралт											
НЭГ: УБЦАТ-ийн дэмжих лаборатор ит хийсн зүйжны туршилтын тоо	Төлөв. Бие.	Төо	Тэг	25	50	50	30	Хагас жил	Мониторигийн ильтэл	ТУН	УБЦАТ-Н лабораторийн туршилтын тоо
ХОЁР: Санал болгосон зүйжны затварууды н тоо	Төлөв. Бие.	Төо	Тэг	17							Дэмжигдсэн халаалтын хэрэгслийн тоо

ГУРАВ: УБЦАТ-Ч батлагдсан зүүхны тоо	Төлөв. Биел.	тоо тоо	тэг тэг	0 4	3 0	4 3	5 4	Хагас жил жил	Мониторинг ийн илтээл ийн илтээл	ТУН ТУН	Төслийн дэмжэлийг авахаар батлагдсан зүүхны тоо
ДӨРӨВ: Татаасын зарцуулалт	Төлөв. Биел.	Татаасын сантас зарцуулсан хөрөнгийн хувь	0 20%	0 0	0 40%	0 60%	100 % %	Хагас жил жил	Мониторинг ийн илтээл ийн илтээл	ТУН ТУН	Сангаас зарцуулсан хөрөнгийн хувь
Дунд түвшинийн үр дунд \ бүрэлдэхүүн хэсэг Хоёр\: Улаанбаатарын төв орчмын гэр хорооллын утааг бууруулах											
НЭГ: Хотын ногоон байгуулам -жийн судалгааг бэлтгэсэн байх	Төлөв. Биел.	Үйл ажиллагаа Биел.	тэг тэг	Зөвлөх сонгох, эхэлэхийн тайланг өгөх	Урьдчилса н тайланг өгөх	Эцсийн тайланг өгөх		Хагас жил жил	Мониторинг ийлтээл ийлтээл	ТУН ТУН	Судалгааг бэлтгэсэн байх
ХОЁР:Хотын ногоон байгуулам -жийн туршилтын төсөл хэрэгжсэн байх	Төлөв. Биел.	Үйл ажиллагаа Биел.	тэг тэг	Эхэлэхийн болон явцын тайланг өгсөн. Явцын семинаар 2 удаа хийсэн.							Туршилтын төсөл хэрэгжүүлэх төслийг хэрэгжүүлэх
ГУРАВ: Цахилгаан станицийн утааг бууруулах ТЭЭУ боловсруул ах	Төлөв. Биел.	Үйл ажиллагаа Биел.	тэг тэг	0 0	0 0	Тодорхойл сон		Хагас жил жил	Мониторинг ийлтээл ийлтээл	ТУН ТУН	Туршилтын төсөл хэрэгжинэ
ДӨРӨВ: Төлбөрийн чадварг НИЙЦСЭН	Төлөв. Биел.	Үйл ажиллагаа Биел.	тэг тэг	Зөвлөхүүдийг сонгоноо, эхэлэхийн өгнө	Илтгэлийн төслийг өгнө	Илтгэлийн төслийг өгнө		Хагас жил жил	Мониторинг ийлтээл ийлтээл	ТУН ТУН	Судалгааг бэлэн боловсруул ах
				Гэрээ байгуулсан. Эхэлэхийн тайланг өгсөн							Судалгааг бэлэн боловсруул ах
				Зөвлөхүүдийг сонгоноо, сурь илтээхийг өгнө	Илтгэлийн төслийг өгнө	Илтгэлийн төслийг өгнө		Хагас жил жил	Мониторинг ийлтээл ийлтээл	ТУН ТУН	Судалгааг бэлэн боловсруул ах

орон сүүчин стратеги боловсруул ах	Биел.		Гэрээ хийсэн. Эхлэлийн тайлан ньгасан.					
ТАВ: Төвлөрсөн дүлааны хангамжий г боловсронг уй болгох тээзү	Төлөв.	Үйл ажиллагаа	Тэг	Зөвлөхүүдийг сонгоно, сурь илтгэлийг өтнө	Илтгэли йг бүрэн эхэр өтнө	Хагас жил	Мониторинг илтгэл	ТУН Судалгаа бэлэн болно
				Гэрээ хийсэн Эхлэлийн тайлан ньгасан.				
Дунд түвшингийн үр дүн \ бүрэлдэхүүн хэсэг Гурав \ олон нийтийн ухамсарыг дээшүүлэх, хөтөлбөрийн зохицуулалт, таслийн менежмент								
НЭГ: Хэмжигүүлэлт н тоног техөөрөмжийн ханган нийлүүлэлт	Төлөв.	Төндөрийн батцын нийт тоо	0	0	0	1	2	3 Хагас жил Мониторинг илтгэл Олгосон техөөрөмж
	Биел.			1				
ХОЁР: Агаарын чанарт хянагт тавих, шинжилгээ хийх, менежмент ийн сургалтад хамрагдса н хүний тоо	Төлөв.	Сургалтад хамрагдсан нийт хүний тоо	0	0	0	5	10	15 Хагас жил Мониторинг илтгэл (Лабораторийн тоног төхөөрөмж)
	Биел.							
ГУРАВ: Төслийн үр дүнгийн менежмент , тайлантаж ажлыг хэвшүүлэх дөрөв: Хотын захиргаана ас бэлтгэсэн	Төлөв.	Төслийн үйл явцын тайлархи тайланний тоо	0	2	2	2	2	2 Хагас жил Мониторинг илтгэл Сургалтад хамрагдсан хүний тоо Шаардлагтаа хангах төслийн явцын тухай илтгэлүүд
	Биел.			4 /улирлын тайлан/				
	Төлөв.	Тайлантгийн тоо	0	3	4	4	4	4 Хагас жил Мониторинг илтгэл Агаарын чанарын хөтөлбөрийн илтгэлүүд

агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зөхичуулал тхийсан түхай тайлан	Биел.		0						
ТАВ: ЗӨХИЧУУЛА ЛТЫГ ХАРИУЦАХА АР ХӨЛСӨЛН АВСАН ЗӨВЛӨХҮЧД	Төлөв.	Нийт ЗӨВЛӨХҮЧДИЙН ТОО	0	2	1	1	1	Хагас жил	Мониторинг ИЛТГЭЛ
ЗУРГАА: ДОНОРУУД БОЛООД АГЕНТЛЯГУУ ДАВАС	Төлөв. Биел.	Жилийн төлөвлөгөөнүүд ийн тоо	0	1	1	1	1	Хагас жил	Мониторинг ИЛТГЭЛ
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭР ОЛЖ ЦУГЛУУЛСАН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЦААН Ы ТЕЛЕВЛӨГӨӨ	Төлөв. Биел.	Жилийн төлөвлөгөөнүүд ийн тоо	0	1	1	1	1	Хагас жил	Мониторинг ИЛТГЭЛ
ДОЛООС: ХАРИЦААН ХОЛБООНЫ ТЕЛЕВЛӨГӨӨ НИЙ ДАГУУ ХИЙСН АЖЛУУД ЗЭЛЭХ ХУРЬ \\БАЙГУУЛЛА ГҮҮД,	Төлөв Биел.	Товлосон ажлын эзлэх хувь	0	100%	100%	100%	100%	Хагас жил	Мониторинг ИЛТГЭЛ
			95%						

Хавсралт №3. ТВ сурталчилгаа

УБЦАТ-ийн төслийн зар сурталчилгааны хүрээнд хийгдэн ТВ сурталчилгааг хавсралтаар DVD дээр оруулсан.

Үүнд:

1. "Улсын нийслэлдээ, Утаагүй амьдарцгаая"
баримтат кино /Бичлэг 1/
2. Японы NHK ТВ-ийн бэлтгэсэн баримтат кино /
Бичлэг 2/
3. Шторкууд
 - a. Зөв галлагаа /Бичлэг 3/
 - b. Аюулгүй ажиллагаа /Бичлэг 4/
 - c. Чанаарын хяналт /Бичлэг 5/
 - d. Зуух борлуулах хөтөлбөр /Бичлэг 6/
 - e. Ханан пийшинд холбох /Бичлэг 7/
 - f. Сайн муу аав-1 /Бичлэг 8/
 - g. Сайн муу аав-2 /Бичлэг 9/

УЛААНБААТАР-ЦЭВЭР АГААР ТӨСӨЛ
ULAANBAATAR - CLEAN AIR PROJECT

Clip 1/Бичлэг 1

Clip 2/Бичлэг 2

Clip 3/Бичлэг 3

Clip 4/Бичлэг 4

2013 он